

Student Guide to Japan

2019-2020



Бие Даасан Захиргааны Байгууллага
Японы Оюутныг Дэмжих Байгууллага
Japan Student Services Organization



STUDY in JAPAN

Chapter 1 ЯПОНД СУРАХ

- | | |
|--------------------------------------|----------------------------|
| 01 Японд сурахын давуу тал | 07 Японд сурахаар төлөвлөх |
| 02 Япон гэж ямар орон бэ? | 08 Хуваарь |
| 04 Яагаад Японд сурч байгаа вэ? | |
| 05 Миний Японд сурах болсон шалтгаан | |
| 06 Оюутны өдрийн тэмдэглэл (1) | |

Chapter 2 СУРГУУЛЬ БОЛОН ШАЛГАЛТ

- | | |
|--|--|
| 10 Японы боловсролын тогтолцоо | 20 Мэргэжлийн сургууль (ТМС-ийн мэргэжил олгох курс) |
| 12 Их дээд болон богино хугацааны дээд сургууль | 22 Япон хэлний сургалтын байгууллага |
| 14 Аспирантур | 24 Японд суралцах шалгалт (EJU) |
| 17 Англи хэлээр боловсролын зэрэг авах анги | 26 Японд сурахад өгөх шалгалтууд |
| 18 Богино хугацаагаар суралцах, явцын дундаас орох | 27 Оюутны өдрийн тэмдэглэл (2) |
| 19 Техникийн коллеж | |

Chapter 3 ЯПОНД АМЬДРАХ

- | | |
|------------------------------------|--|
| 28 Улсын хилээр нэвтрэх бүрдүүлэлт | 38 Цагийн ажил |
| 32 Японд сурахад гарах зардал | 39 Амьдрах байр сууц |
| 33 Амьжиргааны өртөг, юмны үнэ | 40 Эрүүл мэнд, хохирлын болон оюутны даатгал |
| 34 Сургалтын төлбөр | 41 Дадлага хийх |
| 36 Тэтгэлэг | 42 Японд ажилд орох |

Chapter 4 ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭХ

- 43 Статистик
- 44 Японд суралцах талаарх асуулт хариулт / Японд сурахыг дэмжих төслийн гадаад салбарууд
- 45 Мэдээлэл цуглуулах

Зураг гаргаж өгсөн байгууллага: Эдийн Засаг, Аж Үйлдвэрийн Яам, Киото их сургууль, Очаномизү эмэгтэйчүүдийн их сургууль, Жёжи их сургууль, Тоокай дээд сургууль, Анабуки групп коллеж, Окинава Laugh&Peace мэргэжлийн сургууль, Ажиномото компанийн Бразил дахь салбар

ЯПОНД СУРАХЫН ДАВУУ ТАЛ*Why Study in Japan?***ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭХ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН**

Японд сурахын хамгийн том давуу тал бол дэвшилтэт технологи, мэдлэгээс сурах боломжтой явдал юм. Ялангуяа, ШУ-ны салбарт дэлхийн түүчээ болон явж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд Нобелийн шагналтнууд бараг жил бүр төрөн гарч байна. Автомашин, дижитал камер, шилэн кабель, хиймэл зүрх гэх мэт ШУ-ны дэвшилтэт технологийг бүрэн ашигласан бүтээгдэхүүнүүд дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, хүмүүсийн амьдралд тус болсоор байна.

**СУРГАЛТЫН ТӨЛБӨР НЬ БОЛОМЖИЙН**

Японы их дээд сургуулийн сургалтын төлбөр нь Америк, Англи зэрэг улсуудынхтай харьцуулахад өндөр биш. Тухайлбал, Америкийн хот, мужийн их дээд сургуулийн төлбөрийн 1/3-тэй тэнцэх хэмжээний байдаг. Мөн гадаад оюутнуудад тэтгэлэг олгох болон хичээлийн төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх тогтолцоо ч сайн хөгжсөн байдаг.

ДАЯАРШСАН ОРЧИН

Дэлхийн 180 гаруй улс орноос ирсэн 300,000 орчим гадаад оюутнууд одоо Японы их дээд болон япон хэлний сургуулиудад суралцаж байна. Эдийн засаг нь ихээхэн хурдтайгаар өсч буй Ази нь дэлхий дахины анхаарлыг татаад буй бүс нутаг билээ. Иймээс Японд суралцах нь Японыг төдийгүй дэлхий нийтийг судлахтай холбогдож ирнэ. Мөн япон хэл судлалгүйгээр англи хэл дээр боловсролын зэрэг авах боломжтой анги курсууд ч олон болж байна.

**ҮЗЭСГЭЛЭНТ БАЙГАЛЬ, БАЯЛАГ СОЁЛ**

Хавар, зун, намар, өвлийн 4 улирлыг сайхан өнгөрүүлж болох үзэсгэлэнт байгальтай орон. Мөн далай тэнгисээр хүрээлэгдсэн Японд эртнээс өвөрмөц соёл бүрэлдэж ирсэн. Одоо цайны ёслол болон икэбана зэрэг уламжлалт соёл, анимэ, манга зэрэг поп соёл зэрэгцэн оршиж байна. Япон хоол нь Юнескогийн биет бус соёлын өвд бүртгэгдсэн агаад тухайн улирлын материалыг голчлон хэрэглэдэг. Иймээс ч өнгөлөг, олон төрлийн, эрүүл мэндэд тустай хоол гэдгээрээ дэлхий нийтийн анхаарлыг татсаар байна.

ЯПОНД АЖИЛД ОРОХ

Сүүлийн жилүүдэд иргэний харьяалал үл харгалзан шилдэг гадаад оюутныг ажилд авах нь ихэсч байна. Гадаад оюутнууд олон улсын гүүр болох, аливаа зүйлийг олон өнцгөөс харах зэргээр байгууллагад эрч хүч нэмдэг. Японд том төдийгүй жижиг дунд ААН-үүд ч дэлхийд тэргүүлэх технологи, зах зээлд эзлэх байр сууриараа дээгүүрт ордог шилдэг ААН компаниуд олон бий. Иймээс Японд ажилд орох нь таны ирээдүйд хэрэг болох мэдлэг туршлага хуримтлуулах сайхан боломж болох болов уу.



ЯПОН ГЭЖ ЯМАР ОРОН БЭ?

1

Дундаж наслалт: Дэлхийд 1-р байр

1

Үйлдвэрлэлд ашиглагдаж буй роботын тоо: Дэлхийд 1-р байр

3

НҮБ-д оруулах хөрөнгө: Дэлхийд 3-р байр

3

ҮНБ (GNI): Дэлхийд 3-р байр

3

Автомашин экспортын тоо хэмжээ: Дэлхийд 3-р байр

Японоос төрсөн нобелийн шагналтнууд: 26 хүн (Дэлхийд 7, Азид 1-р байр)

Дэлхийн Энх Тайваны Индекс: Дэлхийд 9-р байр (Азид 2-р байр)

Хүн ам: Дэлхийд 11-р байр

Дэлхийн өвийн тоо: Дэлхийд 12-р байр (Азид 4-р байр)

Эх сурвалж: Хүүхдийн ГХЯ, "Орчлон дэлхийн элдэв сонин ранкинг"

Эх сурвалж: Дэлхийн Энх Тайваны Индекс, 2018 он
Иш татсан: Боловсрол Шинжлэх Ухааны статистикийн эмхэтгэл, 2018 он

Иш татсан: Нобелийн сангийн материал

Японы талаарх үндсэн мэдээлэл

Нутаг дэвсгэр: 378,000км²

Хүн ам: 126,420,000 хүн

Нийслэл: Токио

Хэл: Япон хэл

Мөнгөн тэмдэгт: йен (¥)

Эх сурвалж: Дотоод Хэргийн Яам, Статистикийн Хэлтэсийн тайлан (2018 оны 12 сар)

Чюүкоку бүс нутаг

Шиманэ

Окаяма

Хирошима

Ямагүчи

Эхимэ

Коочи

Фүкүока

Сага

Ооита

Нагасаки

Күмамото

Миязаки

Кюшю, Окинава бүс нутаг

Кагошима

Окинава

ҮЗЭСГЭЛЭНТ БАЙГАЛЫ! АМТАТ ХООЛ! АРВИН ТҮҮХ!



ЯПОНЫ ТАЛААРХ ВЭБ ХУУДСУУД

- Web Japan (ГХЯ)
<https://web-japan.org/>
- Японы Үндэсний Аялал Жуулчлалын Байгууллага (JNTO)
<https://www.jnto.go.jp/>
- Сэтгэл татам Японы хөдөө орон нутаг
(Аялал Жуулчлалын Агентлаг)
<http://www.mlit.go.jp/kankocho/cruise/index.html>

ЯАГААД ЯПОНД СУРЧ БАЙГАА ВЭ?

Японд суралцаж буй оюутнуудаас асуулаа!




Яагаад Японд суралцах болсон бэ? (Давхар хариулттай)

<p>1-р байр</p> <p>2-р байр</p> <p>3-р байр</p> <p>4-р байр</p> <p>5-р байр</p> <p>6-р байр</p> <p>7-р байр</p> <p>8-р байр</p> <p>9-р байр</p> <p>10-р байр</p>	<p>Японы нийгэм миний сонирхлыг татдаг тул Японд амьдарч үзэхийг хүссэн 60.8%</p> <p>Япон хэл, соёлоос сурахыг хүссэн 48.2%</p> <p>Японы их дээд сургуулийн боловсрол, судалгааны тогтолцоо сэтгэл татам 34.1%</p> <p>Японтой холбоотой ажилд орохыг хүссэн тул 24.5%</p> <p>Өөр соёлын орчинд байж амьдарч үзмээр байсан тул 23.7%</p> <p>Сонирхож буй мэргэжлийн чиглэл байсан тул 23.6%</p> <p>Найз нөхөд, танил, гэр бүлийнхэн санал болгосон тул ...18.4%</p> <p>Ойрхон тул 17.5%</p> <p>Өөр улсад сурахаар бодож байсан ч сургалтын төлбөр гэх мэт нөхцөл нь хамгийн сайн таарч байсан тул 16.8%</p> <p>Тэтгэлэг авч чадсан тул 5.5%</p>
---	--



Японд суралцаад төрсөн сэтгэгдэл?



Эх сурвалж: "Хувийн зардлаар сурч буй гадаад оюутнуудын аж байдлын судалгаа", 2017 он (JASSO)



Япон болон бусад улс орны олон найз нөхөдтэй болж, тэд нартай байнга харилцаж, хичээлээс гадуурх арга хэмжээнд идэвхтэй оролцсоноор Япон дахь өдрүүдээ үр бүтээлтэй өнгөрүүлсэн.



Гайхалтай чадварлаг судлаачдын дунд болон судалгаа хийх сайхан орчинд судалгааны ажлыг үр бүтээлтэй явуулах боломжтой. Тодорхой зорилго тавин судалгааны ажилдаа сэтгэл зүрхээ зориулаад үзээрэй.



Японы ажил хайх өвөрмөц тогтолцоо нь хэдийгээр хэцүү байсан ч, өөрийгөө таньж, өсч хөгжих дахин олдохгүй сайхан туршлага болсон.

МИНИЙ ЯПОНД СУРАХ БОЛСОН ШАЛТГААН

Өмнө нь болон одоо сурч буй оюутнуудын туршлагаас сонсьё!



Венесуэл

Арироскисмет Дэвид
Токиогийн япон хэлний сургууль

Миний Японы соёлыг сонирхож эхэлсэн шалтгаан бол бусад олон оюутнуудын нэгэн адил анимэ юм. Японы анимэ нь хүүхдэд зориулсан контент хэдий ч нийгмийн бодит асуудлуудыг гүнзгий тусгаж, найз нөхдийн харьяаг сэдэвчлэн харуулсан байдаг нь гүн сэтгэгдэл төрүүлсэн. Хамгийн их гүн сэтгэгдэл төрүүлсэн анимэ бол Конан юм.

Улмаар япон хэл болон япон соёлыг сонирхох болж, ахлах сургуульд байхдаа япон хэл үзье гэж бодон Венесуэл дэх Япон Улсын ЭСЯ-д хандахад япон гэрийн багш танилцуулж өгсөн юм. Түүний дараа дэвшин суралцсан улсын Los Andes их сургуульд 7 хоногт 3 удаа япон хэлний хичээл үзэхээс гадна Японы нийгэм, соёл, ёс жаяг, хичээнгүй ажилсаг ард түмний талаар ч мөн судалсан.

Их сургуульд би систем инженерингээр сурч байсан хэдий ч Венесуэлийн эдийн засгийн байдал муудаж, Венесуэлд сурахад хэцүү болсон. Ингээд систем инженеринг сайн хөгжсөн, мөн бүтээгдэхүүн чанартай хийж ирсэн Японд үргэлжлүүлэн сурья гэж бодох болсон. Мөн Японы соёл болон япончуудтай шууд харьцахыг хүсэх болж, япон хэлээ сайжруулахын тулд аав ээжийгээ ятган хүлээн зөвшөөрүүлж, Японд сурахаар шийдсэн.

Ирээдүйд улс харгалзахгүй, олон улсын инженер эсхүл судлаач болж, хиймэл оюун ухаан зэрэг техникийн хөгжилд хувь нэмэр оруулахыг хүсч байна. Өөрийн компанийг байгуулах мөрөөдөл ч бас бий. Япон улс үнэхээр аюулгүй улс учраас амьжиргааны түвшин өндөр, хүүхдийн сурч боловсроход хамгийн тохирох орчин бүрдсэн газар тул их сургуулиа төгссөний дараа ч Японд үлдэж амьдрах хүсэлтэй байна. Гэхдээ тухайн үеийн Японы эдийн засгийн байдлыг харж байж шийдье гэж бодож байна. Япон нь хөгжсөн улс хэдий ч бэлэн мөнгө одоо хэр нь өргөнөөр ашиглагдсаар байна. Иймээс би бэлэн мөнгөгүй нийгэм хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг хүсч байна.



Энэтхэг

Бишюүгүпта
Шүзюока их сургууль

Би угаасаа эх орноосоо өөр газар их сургуульд сурна гэж боддог байв. Ингээд бодоод үзэхэд Япон нь компьютерын ШУ гэх мэт төрөл бүрийн үйлдвэрлэлийн технологиороо бусад орнуудаас илүү хөгжсөн санагддаг.

Тиймээс тэрхүү мэдлэгийг эзэмшихийн тулд Японд сурахаар шийдсэн.

Мөн би Японы манга болон анимэд дуртай, Японд очиж, анимэ, манганы үйл явдал болж өнгөрсөн бодит газруудаар аялаж үзье гэж боддог болсон. Энэ маань ч бас Японд сурах нэг шалтгаан болсон.

Шүзюока их сургууль байдаг Хамамацу хот нь Японы Цахиурын Хөндий гэж хэлэгддэг бөгөөд ШУ, технологи судлахад хамгийн тохирох орчин бүрдсэн газар билээ. Шизюока их сургуулийн Asia Bridge Program (ABP) хөтөлбөрөөр Японд сурсанаар япон хэлний практик ур чадвар эзэмшиж, мөн Японы нэртэй компаниудад ажилд орох боломжтой.

Тэтгэлгийн тогтолцоо ч мөн адил сайн хөгжсөн бөгөөд ямар нэгэн саад бэрхшээлгүйгээр хичээл сургуулиа анхааран ажиллах боломжтой.



Киргиз

Акматбекова Гүлзат
Риккёо их сургууль

Миний Японд сурах болсон шалтгаан бол халуун рашаан юм. Өөрийн эх орон болох Киргизийн Бишкекийн хүмүүнлэгийн Ухааны их сургуулийн Олон Улсын Харилцааны Факультетэд япон хэл идэвхийлэн сурч, Япон явж үзье гэж мөрөөддөг байсан. Тэгээд 4-р курсэд байхад маань Японы Евразийн Нийгэмлэгийн Шимизү салбарын хамт олон Японд хоёр 7 хоног байх боломж олгож, энэ үед би Японы янз бүрийн соёлтой танилцсан.

Энэ дундаас хамгийн гайхал төрүүлсэн нь миний үзэхийг тэсэн ядан хүлээдэг байсан халуун рашаан байсан юм. Учир нь Киргизийн халуун рашаан нь ЗХУ-ын үеэс эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалтаар ашиглагдаж ирсэн. Ингээд Японд үзэж харсан, гэр бүлтэйгээ болон найз нөхөдтэйгөө хамт орж амарч болох халуун рашааны соёл нь гайхамшигтай байсан тул Киргизийн халуун рашааныг өөрчлөе гэсэн мөрөөдөл тээн Риккёо их сургуулийн аялал жуулчлал судлалын ангид орсон.

Би Японы Күсацү болон Арима халуун рашаанд их дуртай. Тэрээр Японд сурсан мэдлэг туршлагаа ашиглан Киргиз улс Төв Азид халуун рашаанаараа танигдсан улс болж, аялал жуулчлал хөгжихөд нь хувь нэмэр оруулж, Япон, Киргиз хоёр улсын найрамдалт харилцааны гүүр нь болж ажиллахын тулд илүү их хичээл зүтгэл гарган ажиллах болно.



Тайланд

Жаатрам Нармон
Шибяүра их сургууль

Би багаасаа Японы телевизийн нэвтрүүлэгт маш дуртай байсан. Телевизийн нэвтрүүлгээр дамжуулан япон хоол болон Японы технологиос суралцаж, Японыг улам сонирхох болсон.

Японд сурахад хамгийн их түлхэц болсон зүйл бол ахлах сургуулийн 1-р курсэд сурч байхдаа Тайландыг төлөөлөн Японд болсон охид, хөвгүүдийн скаутын дэлхийн тэмцээнд оролцсон явдал юм.

Японы соёлыг биеэр мэдэрсэнээр Японд амьдарч үзэх юмсан гэж бодох болсон.

Ахлах сургуулийн 2-р курсэд сурч байхдаа Тайландын Засгийн Газрын тэтгэлэг авах боломж тохиож, Японд сурахаар шийдсэн. Шибяүра их сургуулийг сонгосон шалтгаан маань нэгдүгээрт мэдээллийн инженерингийн салбар нь дэвшилттэй санагдсан. Мөн өмнө нь суралцаж төгссөн оюутнууд олон улсын харилцаа нь маш сайн хөгжсөн глобал их сургууль гэж зөвлөсөн учраас юм.

Одоо Шибяүра их сургуульд суралцан, мэдээллийн инженеринг судалж байгаа. Төгсөөд Япон болон Шибяүра их сургуульд сурсан зүйлээ Тайландад хэрэгжүүлнэ гэж бодож байна.

ОЮУТНЫ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ (1)

Гадаад оюутнууд өдөр хоногийг хэрхэн өнгөрүүлдэг юм бол? Та бүгдийн эргэлзээг тайлж, Японд сурч буй оюутнуудын амьдралыг нэг тольдон үзье. Мөрөөдлийнхөө төлөө хичээх гадаад оюутнуудын дуу хоолойг сонсоорой.



Одоо би техникийн коллежид сурдаг. Төгсөөд их сургуульд 3-р курсээс нь орж, чадвал аспирантур хүртэл явъя гэж бодож байгаа.



Майзүрү Техникийн Коллеж,
барилгын инженерийн анги

Ипорти (Рүванда)

Манай улс хэдийгээр дэд бүтцээ сайжруулъя гэж ярьж хэлцдэг ч архитектурч болон инженер зэрэг боловсон хүчин хүрэлцдэггүй. Би улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулахыг хүсч буй тул инженерийн чиглэлийн хичээл үзэхийг хүсч байгаа. Япон улс боловсролын түвшин ч өндөр, технологи ч сайн хөгжсөн тул Японд сурвал инженерийн гайхалтай мэдлэг эзэмшиж чадна гэсэн итгэл өвөрлөн Японд ирсэн.

Гэр бүлээсээ анх удаа хол байж үзэж буй тул нэлээдгүй шаналах, хэцүү байдалд орох зэрэг асуудал гарч байсан ч тэр үедээ багш нарынхаа тусламж дэмжлэгийг авсны ачаар Токиогийн япон хэлний сургуулийг төгсөж чадсан.

Түүний дараа техникийн коллежид орсны дараа ч 2 зааварлагч багш мэдэхгүй зүйл гарвал хэдийд ч тусалдаг байсан. Асуудал гарсан үед тусалж дэмждэг хүн заавал байдагт сэтгэл хангалуун байдаг.

Одоо техникийн коллежид инженерийн чиглэлээр сурч байна. Төгсөөд их сургуульд 3-р курсээс нь орох бодолтой байгаа. Тэгээд чадвал аспирантур хүртэл явмаар байна.

Миний мөрөөдөл бол улсдаа өөрийн барилгын компани байгуулж, Японд сурсан ур чадвар, япон хэл, соёл зэргийг улсынхаа залууст зааж сургах явдал юм.

МИНИЙ НЭГ ӨДӨР

8:00 Өглөөний хоол
Өглөө бүр талх, сүү иддэг.

8:45-16:05 Хичээлтэй
Дуртай хичээл маань математик, геотехникийн инженерчлэл. Хэцүү хичээл бол барилгын онол, барилга төлөвлөлт (Тогтоох зүйл ихтэй учир...)


16:10 Хоол хийнэ
Байрандаа очоод оройн хоолоо бэлдэнэ.

18:30 Шүршүүрт орно.
Шүршүүрт орохоосоо өмнө хааяа булчин хөгжүүлэх дасгал хийдэг.

19:00 Оройн хоол
Үргэлж адил биш ч будаа, мах, шош, өндөг, шарсан төмс иддэг.

19:30 Хичээлээ хийнэ.
Ангийн ажил, гэрийн даалгавар зэрэг дээрээ ажиллана.

20:00 Дохио
Байрны дохиолол дуугарна. 21 цагт гэрэл унтрах тул унтана.



Соёлын ивэнт, арга хэмжээнд аль болох идэвхтэй оролцоорой.

Рицүмэйкан их сургууль, Бодлого ШУ-ны факультет, Коммюнити, бүс нутгийн бодлого судлалын анги

Ёшиэ Сасагава (Малайз)

Хэлний бэрхшээлийн улмаас хэцүү байдалд орох тохиолдол гарч байсан ч их сургуулийн танилууд, ойр орчмын хүмүүс үнэхээр тусалж дэмжсэн. Үүнээс илүү гадаадад сурсан туршлага байхгүй л болов уу.

Миний Японд сурахаар шийдсэн шалтгаан бол өөрийн удам (Малайз болон Япон гэсэн 2 удамтай)-ынхаа талаар илүү ихийг мэдэхийг хүссэн явдал юм. Миний сурсан Рицүмэйкан их сургууль нь төрөл бүрийн ивэнт, соёлын арга хэмжээ зохион байгуулж, түүнд оролцох боломжоор гадаад оюутнуудыг хангадаг.

Осакагийн хамгийн том шинто шашины сүмд хийсэн нэг өдрийн

дадлага, хөдөө тосгонд хийсэн хээрийн судалгаа, ХАА-н хөдөлмөрийн дадлага, зуны дадлага, Японы бага сургуулийн хүүхдүүдтэй хамт өнгөрүүлсэн мөч гэх мэт.

Их завгүй юм шиг харагдаж байж магадгүй ч эдгээр туршлагаа авшиглан Японыг илүү гүнзгий мэдэж авсан төдийгүй өөрөө өөрийгөө таньж чадсан юм. 4 жил Японд сураад япончуудын ажилд хандах ёс суртахуун болон өвөрмөц зан заншлаас тэсвэр тэвчээр, амьдрах ухаан суусан гэж боддог. Японд сурахаар ирэхээс өмнө бол энэ тухай ямар ч ойлголт надад байгаагүй. Японд сурч буй хүмүүс, мөн Японд сурахаар төлөвлөж буй та бүхэн илүү уян хатан байж, аль болох янз бүрийн ивэнт, арга хэмжээнд идэвхтэй оролцоорой.



МИНИЙ НЭГ ӨДӨР

7:15-8:15 Өглөөний бэлтгэл
Нүүрээ угаагаад хувцсаа өмсөнө. Өглөөний хоолоо сайн идэж авна.

8:15-9:00 Сургуульдаа явна.
Гэрийнхээ ойр байх буудал хүртэл унадаг дугуйгаар явна. Галт тэргэнд суугаад сургуулийнхаа ойролцоох буудлаас сургууль хүртлээ алхана.

9:00-12:10 Лекц орно
Лекц 90 минут үргэлжилдэг. Дундаа 10 минутын завсарлагатай.

12:10-13:00 Өдрийн хоол
Ихэндээ сургуулийнхаа кафе хуульцгоодог. Хааяа өөрөө хийж ирсэн хоолоо иддэг.

13:00-14:00 Чөлөөт цаг
Хоолны дараа найзтайгаа кофе, десерт идэнтэй гэрийн даалгавраа хийж дуртай.

14:00-16:00 Фитнесс клуб
Фитнесс клубт дасгал хийж, стрессээ тайлна. Нэг өдрийн маань хамгийн дуртай мөч

16:00-17:00 Гэртээ ирнэ.
Сургуулиасаа эрт гарах үедээ замаараа супермаркетаар орж юм худалдан авч, оройн хоолоо хийнэ. Оройн хоолоо идээд хичээлээ хийнэ.

ЯПОНД СУРАХААР ТӨЛӨВЛӨХ

Төлөвлөх нь амжилтын түлхүүр!



Яагаад?

Японд сурах зорилго тань юу болох?

Таны зорьж буй ирээдүйн ажил мэргэжилд ямар мэргэшлийн шалгалт, ур чадвар хэрэгтэй вэ?

What?

Юу?

Юу судлахыг хүсч байна?

Мэргэжил, мэргэшлийн чиглэл?

Where?

Хаянд?

Ямар сургуульд сурвал дээр вэ?

How long?

Ямар хугацаагаар сурах вэ?

Ямар хугацаагаар сурах вэ?

1 Боловсролын зэрэг цол	Бакалавр	Менежмент? Боловсрол судлал? Физик? Инжинеринг? Мэдээлэл зүй? Анагаах ухаан? ХАА? дизайн? Уран зураг? Хувцас загвар? Анимэ?	Их дээд сургууль	4 жил (Зарим сургууль 6 жил)
	Магистр		Аспирантур	2 жилээс дээш
	Доктор		Аспирантур	3 жилээс дээш
	Богино хугацааны дээд сургуулийн бакалавр		Богино хугацааны дээд сургууль	2 жил (Зарим сургууль 3 жил)
	Дэд бакалавр		Техникийн коллеж	3 жил (Зарим анги 3 жил 6 сар)
	Мэргэжилтэн		Мэргэжлийн сургууль	2-3 жил
	Нарийн мэргэжилтэн		Мэргэжлийн сургууль	4 жил

2 Богино хугацаагаар сурах	Богино хугацаагаар сурах	<ul style="list-style-type: none"> • Япон хэл • Япон соёл • Харьцуулсан соёл судлал 	Япон хэлний сургууль, дээд сургуулийн богино хугацааны хөтөлбөр	Хэдэн сараас нэг жил хүртэл
	Оюутан солилцоо		Их дээд сургууль	Нэг жил хүртэл

3 Япон хэл судлах	Хэл сурах	<ul style="list-style-type: none"> • Дэвшин сурах курс • Япон хэлний яриа • Бизнесийн япон хэл 	Япон хэлний сургууль	2 жил
	Дэвшин сурах		Япон хэлний сургууль	2 жил
			Хувийн их дээд сургууль, богино хугацааны дээд сургууль, гадаад оюутнуудад зориулсан тусгай курс	1-2 жил

When?



Хэзээ?

Хэзээ явах?

Хэзээ эхлэх?

Бэлтгэлд хэр их хугацаа орох?

How much?



Заргал мөнгө?

Хэр их зардал гарах бол?

Тийзний үнэ? Амьжиргааны өртөг? Түрээсийн төлбөр? Хоол хүнсний зардал? Хадгаламж хүрэх эсэх? Ар гэрээс мөнгө явуулах эсэх? Цагийн ажил? Тэтгэлэг?

Хуудас 8-9 дэх "Хуваарь"-ийн дагуу төлөвлөөрэй!

Хуудас 32-40-ийг харан тооцоолоод үзээрэй!

ХУВААРЬ

Японд суралцах төлөвлөгөөгөө гаргаж чадсан уу? Ингээд бэлтгэл ажлаа хэрхэн хангах талаар багцаа байдлаар төлөвлөгөө гаргаад үзье.

СУРАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХААС ЯПОН ЯВАХ ХҮРТЭЛ

plan 1 **Зөвхөн япон хэл үзэхийг хүсэж буй бол**
 1-8 нь өөрийн улсад хийх бэлтгэл, 9 нь Японд хийх бэлтгэл, 10 нь япон хэлний сургуульд элсэн орох үе шат, 11 нь япон хэлний сургууль төгсөх үе шат

plan 2 **Япон хэл үзээд их дээд болон мэргэжлийн сургуульд элсэн орохыг хүсэж буй бол**
 1-8 нь өөрийн улсад хийх бэлтгэл, 9 нь Японд хийх бэлтгэл, 10 нь япон хэлний сургуульд элсэн орох үе шат. Япон хэлний сургуульд сурч байхдаа 12-22-ын бэлтгэлийг хангана. 23 нь япон хэлний сургууль төгсөх үе шат, 24 нь их дээд болон мэргэжлийн сургуульд элсэн орох үе шат


plan 3 **Өөрийн улсаас Японы их дээд болон мэргэжлийн сургуульд шууд дэвшин сурахыг хүсэж буй бол**
 Япон хэлний хангалттай мэдлэг чадвартай, эсхүл англи хэлээр явагдах хичээлд хамрагдах бодолтой байгаа танд 2-11-ыг алгасаад 12-ын элсэлтийн материал авахаар хандах гэдгээс эхэлнэ. Элсэлтийн шалгалтанд тэнцсэн бол зохих бичиг баримтын бүрдүүлэлтийг хийгээд 24 дэх шатан дээр их дээд сургууль болон мэргэжлийн сургуульд элсэн орно.

Зуучлагч байгууллагаар үйлчлүүлэх

Японд суралцахаар өөрөө хөөцөлдөх нь эдийн засгийн хувьд ашигтайн дээр өөрт тань үнэлж дүгнэх чадвар сууж, хэлний чадвар сайжрахад нөлөөлөх давуу талтай. Гэсэн хэдий ч зав муутай байх болон хэлний чадвар тааруу бол сургуульд зуучлагч байгууллагад хандаж болно.

Сонголт хийхдээ анхаарах зүйлс!

- 1. Зардал** Зуучлалын хэд хэдэн компаниудыг харьцуулж үзээд санал болгож буй үнэ нь үндэслэлтэй эсэхийг тогтоох, Японд цагийн ажил хийгээд сургалтын төлбөр болон амьжиргааны зардлаа бүгдийг олж чадна гэж хэлж буй эсэх, төлбөр болон үйлчилгээний агуулгыг гэрээнд тодорхой заасан эсэхийг харах
- 2. Үйлчилгээ** Сурах зорилгод тань нийцсэн сургуулийг танилцуулж байна уу, хуурамч бичиг баримт бүрдүүлэн хил нэвтрэх талаар санал болгож байна уу, асуултад болон бүрдүүлэлтийн явцын талаар сэтгэлд нийцсэн хариулт хэлж байна уу, бүртгүүл гэж шавдуулж байна уу, Японд сурахын давуу тал төдийгүй сул талын талаар тайлбарлан хэлж байна уу?
- 3. Туршлага** Япон руу оюутан зуучилж байсан хангалттай туршлагатай эсэх




Алхам	Хамаарах хуудас	Хугацаа		Үйлдэл
1 Төлөвлөх, мэдээлэл цуглуулах	7, 32-35			Сурах зорилгоо тодорхойлох, шаардлагатай хэлний түвшин болон сурах зардал мөнгөө тооцоолох
2 Япон хэлний сургуулийн элсэлтийн материал авахаар хүсэлт гаргах	22, 23	4-6 сар	10-12 сар	Суралцахыг хүсч буй хэд хэдэн сургуулийн танилцуулга, элсэлтийн бичиг баримтыг хүлээн авах. Элсэн орох шалгуурыг мэдэх
3 Сургууль сонгох	22, 23	9 сар хүртэл	2 сар хүртэл	Сургуулийн танилцуулга зэргээс сурахыг хүсч буй сургуулиа сонгох
4 Сургуульд элсэх өргөдөл гаргах	22, 23	9-11 сар	2-4 сар	Сургуульд элсэх өргөдөл болон бусад холбогдох бичиг баримтыг сурахыг хүсч буй сургууль руугаа илгээнэ
5 Сургуульд элсэх зөвшөөрөл гарна				Сургуульд элсэх зөвшөөрөл хүлээж авна. Сургалтын төлбөр зэргийг шилжүүлнэ.
6 Япон явах бичиг баримтаа бүрдүүлэх	28-31			Оршин суух зөвшөөрлийн бичиг хүлээн авсны дараа виз мэдүүлнэ.
7 Японд сурах бэлтгэлээ хийх		1-3 сар	7-9 сар	Оршин суух байр хайна.
8 Япон руу нисэх бэлтгэл хийх, Япон явах				Тийз, даатгалаа хөөцөлдөнө.
9 Сургуульд элсэх бичиг баримтын бүрдүүлэлт хийх				
10 Япон хэлний сургуульд элсэн орж, хичээлээ үзэж эхлэх		4 сар (1 ба 2 жилийн курс)	10 сар (Жил хагасын курс)	
11 Япон хэлний сургуульд бичиг баримт авахаар хандах				

12 Их дээд болон мэргэжлийн сургуульд бичиг баримт авахаар хандана.	12-21	4-5 сар / 9-10 сар		Сурахаар сонирхож буй хэдэн сургуулийн танилцуулга, элсэлтийн бичиг баримт хүлээн авна. Элсэн орох шалгуур хангаж буй эсэхээ магадлана.
13 Сургуулиа сонгоно.	12-21	6 сар хүртэл / 11 сар хүртэл		Сургуулийн танилцуулга зэргээс сурахыг хүсч буй сургуулиа сонгоно.
14 Японд суралцах шалгалт (EJU) өгөхөөр бүртгүүлнэ.	24-25	7 сар хүртэл / 3 сар хүртэл		Японд суралцах шалгалт (EJU)-д бүртгүүлж, шаардагдах шалгалтуудыг өгнө. Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT) TOEFL®, IELTS, TOEIC® өгнө (Шаардлагатай тохиолдолд)
15 Сургуульд элсэх өргөдөл гаргана.	12-21	8-10 сар/1 сар-11 сар		Элсэх өргөдөл, бусад шаардагдах бичиг баримтыг сургууль руугаа илгээнэ.
16 Шалгалт өгнө.		11-2 сар/ 3-8 сар		Бичиг баримтын шалгаруулалт, Японд сурах шалгалт (EJU) өгч, суралцахыг хүсч буй сургуулийнхаа элсэлтийн шалгалтыг өгнө.
17 Сургуульд орох зөвшөөрөл авна.				Сургуульд орох зөвшөөрөл хүлээн авна.
18 Япон явах бичиг баримтын бүрдүүлэлт хийнэ.	28-31			Оршин суух зөвшөөрөл авсны дараа виз мэдүүлнэ.
19 Сурах бэлтгэлээ базаана.				Сургалтын төлбөрөө шилжүүлнэ. Оршин суух байр хайна.
20 Оршин суух хугацаагаа сунгуулах, ажиллах байгууллагын мэдээлэл гаргаж өгнө.		1-3 сар / 6-8 сар		
21 Япон явах бичиг баримт бүрдүүлж, Япон явна.				Тийз, даатгалаа хөөцөлдөнө.
22 Сургуульд элсэж орох бичиг баримт бүрдүүлнэ.				
23 Япон хэлний сургууль дүүргэнэ.				
24 Их сургууль, мэргэжлийн сургуульд элсэн орно.		4 сар / 9 сар, эсхүл 10 сар		* Намар хичээл нь эхэлдэг (9, 10 сар) зарим нэг сургууль ч бий.
25 Их сургууль, мэргэжлийн сургууль төгсөнө.		3 сар / 8 сар, эсвэл 9 сар		* Өргөдөл гаргахаас сургуульд элсэн орох хүртэлх процедур сургуулиасаа хамаараад өөр байдаг. Тухайн сургуулийн оюутан шалгаруулах журамтай сайтар танилцаж, бүрдүүлэлт хийхдээ алдаа гаргахгүй байх тал дээр анхаараарай.

ЯПОНЫ БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО


Японы дээд боловсрол нь анхан шатны боловсрол (Бага сургууль 6 жил) болон дунд боловсрол (Дунд сургууль 3 жил, ахлах сургууль 3 жил) гэсэн нийт 12 жилийн боловсролыг дүүргэсний дараа эхэлдэг. Гадаад оюутан элсэн орох боломжтой дээд боловсролын байгууллага нь 1) Техникийн коллеж, 2) Мэргэжлийн сургууль (ТМС-ийн мэргэжил олгох курс), 3) Богино хугацааны дээд сургууль, 4) Их сургууль (факультет), 5) Аспирантур гэсэн 5 төрөлтэй. Үүсгэн байгуулсан субъектээс нь хамааруулан улсын, нийтийн, хувийн гэж ангилдаг.



1. Хичээлийн жилийн календарь, семестрийн тогтолцоогоо магадлаарай!

Японы сургуулиудын хичээлийн жил ихэвчлэн 4 сараас дараа оны 3 сар хүртэл үргэлжилдэг. Японы олонхи их дээд сургууль семестр /2 семестр/-ийн тогтолцоотой бөгөөд эхний семестр нь 4-9 сар хүртэл, 2 дахь семестр нь 10-3 сар хүртэл байдаг. 3 болон 4 семестртэй их дээд сургууль ч байдаг. Японд ерөнхийдөө 4 сард хичээлийн шинэ жил нь эхэлдэг хэдий ч, ялангуяа аспирантуртаа 9 болон 10 сард элсэлт авах их дээд сургууль их байдаг.

4 сард элсэн ороод 2 семестрээр суралцах оюутны нэг жил



2. Элсэлтийн шалгууртай танилцаарай!

Японы их дээд сургууль (Факультет), богино хугацааны дээд сургууль, мэргэжлийн сургуульд элсэн орохын тулд зарчмын хувьд 12 жилийн албан боловсрол эзэмшсэн байх шаардлагатай.

Харин техникийн коллежид явцаас ороход 11 жил, аспирантурт (магистр)-т элсэхэд 16 жилийн боловсрол эзэмшсэн байх шаардлагатай.

Энэтхэг, Непал, Бангладеш, Малайз, Мьянмар, Монгол, Перу зэрэг улсад 10 эсхүл 11 жилийн боловсрол эзэмшсэн хүмүүс Японы их дээд сургуульд элсэн орохын тулд баруун талын шалгуур үзүүлэлтийн аль нэгийг хангасан байх шаардлагатай.

Гэхдээ баруун талын нөхцөлөөс гадна тухайн сургууль өөрийн шаардлагыг тавих тохиолдол бий. Иймээс элсэлтийн шалгуур хангасан эсэх тань тодорхойгүй бол тухайн сургуулиасаа тодруулаарай.

1. Өөрийн орондоо их дээд сургуульд орохын өмнөх бэлтгэл сургалт юмуу их дээд сургуульд 1-2 жил суралцаж, албан ёсны сургуулийн боловсролын 12 жилийг дүүргэсэн байх

2. Японы Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын заасан бэлтгэл сургалт¹-ыг дүүргэсэн байх (Японы ахлах сургуультай дүйцэх боловсрол эзэмшсэн байх)

Харин бүрэн дунд боловсролын систем нь 12 жил хүрээгүй хүмүүсийн хувьд Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын заасан 11 жилээс дээших боловсрол²-ыг тухайн улсад сурч дүүргэсэн бол бэлтгэл сургалтад хамрагдахгүйгээр элсэн орох боломжтой.

¹ **Японы Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын заасан "Бэлтгэл сургалт"**

https://www.jasso.go.jp/ryugaku/study_j/search/nihongokyouiku.html

² **"БШУС-ын заасан" 11-ээс дээш жилийн боловсрол"**

http://www.mext.go.jp/a_menu/koutou/shikaku/1380756.htm

3. Боловсролын зэрэг цол, суралцах жилээ тодруулж хараарай!

	Анги, курс	Олгогдох боловсролын зэрэг цол	Суралцах үндсэн хугацаа
Аспирантур	Докторын анги ^{*1}	Доктор	5 жил
	Магистрын анги	Магистр	2 жил
	Нарийн мэргэжлийн зэрэг олгох анги (Professional Degree)		Магистр (Нарийн мэргэшлийн)
Хуулийн доктор (Нарийн мэргэшлийн)			3 жил
Боловсролын магистр (Нарийн мэргэшлийн)			2 жил
Их дээд сургууль (факультет)	Ердийн бакалаврын сургалт, 4 жилийн эм зүйн анги	Бакалавр	4 жил
	Анагаах ухаан, шүд ам судлал, мал эмнэлгийн анги, 6 жилийн сургалттай эм зүйн анги		6 жил
Богино хугацааны дээд сургууль ^{*2,3,5}	2 жилийн анги	Богино хугацааны дээд сургуулийн бакалавр	2 жил
	3 жилийн анги		3 жил
Нарийн мэргэшил олгох дээд сургууль	-	Бакалавр /Нарийн мэргэшил/	4 жил
Нарийн мэргэшил олгох богино хугацааны дээд сургууль ^{*2,3,5}	2 жилийн анги	Богино хугацааны дээд сургуулийн бакалавр /Нарийн мэргэшил/	2 жил
	3 жилийн анги		3 жил
Техникийн коллеж ^{*3,4,5}	-	Дэд бакалавр	3 жил (Худалдааны хөлөг онгоцных 3 жил 6 сар)
Техник мэргэжлийн сургууль ^{*4}	Мэргэжлийн олгох курс (Мэргэжлийн сургууль)	Мэргэжилтэн	2-оос дээш жил
		Дээд зэргийн мэргэжилтэн	4-өөс дээш жил

*1 Аспирантур нь эхэн (2 жил) болон сүүлийн шатны (3 жил) гэж ангилагддаг. Бакалаврын сургалт нь 6 жил үргэлжилдэг анагаах ухаан, шүд эрүү нүүр судлал, 6 жилийн сургалттай эм зүйн болон мал эмнэлгийн ангийн докторын сургалтын үндсэн хугацаа 4 жил байдаг.

*2 Богино хугацааны дээд сургууль төгссөний дараа гүнзгийрүүлсэн курс (1-2 жилийн)-т дэвшин суралцаж, "Бакалавр"-ын зэрэг авах боломжтой.

*3 Техникийн коллежид суралцах үндсэн хугацаа 5 жил байдаг боловч гадаад оюутныг 3-р курсээс эхлэн хүлээж авдаг. Төгссөнийхөө дараа гүнзгийрүүлсэн курс дэвшин суралцаж, "Бакалавр"-ын зэрэг авах боломжтой.

*4 Техникийн коллежийн "дэд бакалавр", мэргэжлийн сургуулийн "мэргэжилтэн", "дээд зэргийн мэргэжилтэн" нь цол юм.

*5 Их Дээд Сургуулийн Шинэчлэл, Боловсролын Зэрэг Олгох Асуудал Эрхэлсэн (NIAD-QE) Байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн богино хугацааны дээд сургууль, техникийн коллежийн мэргэжлийн ангийг дүүргэж, тус байгууллагын шалгалтад тэнцвэл "Бакалавр"-ын зэрэг авах боломжтой. Дэлгэрэнгүйг элсэхийг хүсч буй сургуулиасаа лавлаарай.



Боловсролын зэрэг олгох ажил (Их Дээд Сургуулийн Шинэчлэл, Боловсролын Зэрэг Олгох Асуудал Эрхэлсэн Байгууллага)
<http://www.niad.ac.jp/english/adegrees>

Q Японд авсан боловсролын зэрэг бусад улс оронд хүчинтэй юу?

A Япон улсад авсан боловсролын зэрэг бусад улсад авсан боловсролын зэрэгтэй нэгэн адил хүчинтэй. Гэхдээ зарим улсын Боловсролын Яам болон магадлан итгэмжлэх байгууллага (ашгийн бус болон хувийн хэвшлийн байгууллага зэрэг) гадаадад авсан боловсролын зэргийг үнэлэх тохиодол байдаг. Тиймээс өөрийн орны холбогдох байгууллагаас лавлаж тодруулаарай.

ИХ ДЭЭД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Дээд боловсролын цөмийг бүрдүүлдэг боловсролын байгууллага болох их дээд сургуульд суралцах хугацаа үндсэндээ 4 жил, богино хугацааны дээд сургуулийнх 2 жил байдаг. Сургуулиасаа хамаараад сонсогч оюутан, кредит аван суралцагч оюутны тогтолцоо ч бас бий. Боловсролын зэрэг авах зорилгоор урт хугацаагаар суралцахаас гадна боловсролын зэрэг авахгүйгээр мөн богино хугацаагаар суралцаж (Хуудас 18-ыг харах) болно.


1. Элсэлтийн шалгуураа магадлаарай!

Доорхи шалгуурын аль нэгийг хангасан байх шаардлагатай.

1. Японоос бусад улсад 12 жилийн боловсрол эзэмшсэн байх
 2. Японоос бусад улсад 12 жилийн боловсрол эзэмшсэнтэй дүйцэх боловсрол эзэмшсэнийг батлах шалгалтанд тэнцэж, 18 нас хүрсэн байх
 3. Гадаад улсын ахлах сургуультай дүйцнэ хэмээн магадлан итгэмжлэгдсэн Япон улс дахь гадаад сургуулийг төгссөн байх
 4. Япон улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын хүлээн зөвшөөрсөн 11-ээс дээш жилийн боловсролыг гадаад улс оронд эзэмшсэн байх
 5. Олон улсын бакалавр, абитур, Франц улсын бакалавр зэрэгтэй, эсвэл GCE A (General Certificate of Education: Advanced level-Англи гэх мэт улсын ерөнхий боловсролын А түвшний шалгалт) шалгалтанд хангалттай дүн үзүүлсэн байх
 6. Олон улсын үнэлгээний байгууллага болох “WASC, CIS, ACISI”-ын магадлан итгэмжилсэн сургуульд 12 жил сурч төгссөн байх
 7. Ахлах сургууль төгссөнтэй дүйцэх боловсрол эзэмшсэнийг батлах шалгалтад тэнцсэн, 18 нас хүрсэн байх
 8. Сургуулийн боловсролын хуулинд заасан дээрхээс бусад элсэх шалгуур дотроос аль нэг шалгуур үзүүлэлтийг хангасан байх
 9. Тухайн сургуулийн элсэлтийн тусгай шалгалтаар ахлах сургууль төгссөнтэй дүйцэхүйц сурах чадвартай нь тогтоогдсон, 18 нас хүрсэн байх
- ※ 1.-3.-ын хувьд суралцсан хугацаа нь 12 жил хүрээгүй бөгөөд гадаад улсын нэр бүхий боловсролын байгууллагад суралцан төгсөөгүй бол нэр бүхий бэлтгэл сургалт юм уу сургалтын байгууллагад курс дамжаа дүүргэх шаардлагатай болох тохиолдол гарна.

2. Сургуулиа хайя!

Их дээд болон богино хугацааны дээд сургууль сонгохдоо анхаарах зүйлс





Их дээд болон богино хугацааны дээд сургуулиудын мэдээлэл (JASSO)

https://www.jasso.go.jp/en/study_j/search/daigakukensaku.html



Их дээд болон богино хугацааны дээд сургууль хайх (JAPAN STUDY SUPPORT)

<https://www.jpss.jp/en/>

• Хувийн зардлаар суралцах гадаад оюутанд зориулсан их дээд сургуулийн танилцуулга

Энэхүү гарын авлагад их дээд сургуулиудын элсэлтийн шалгалтын агуулга, элсэлтийн шалгалтад тэнцсэн гадаад оюутны тоо гэх мэт их хэрэгтэй мэдээлэл орсон байгаа.

Хянан тохиолдуулж, хэвлэсэн: Азийн Оюутны Соёлын Холбоо (Япон улсад худалдаалдаг)

※ Японд суралцах материал, гарын авлагатай танилцах цэг (Хуудас 45-ийг харах) дээр танилцах боломжтой.



3. Элсэлтийн материалаа магадлаарай!

1. Сургуульд элсэх өргөдөл (Тухайн сургуулийн албан маягтаар)
2. Ахлах сургуулийн төгсөлтийн (төгсөх гэж буйг нотлох) гэрчилгээ
3. Ахлах сургуулийн дүнгийн тодорхойлолт
4. Төгссөн сургуулийн захирал буюу багшийн тодорхойлолт
5. Япон, англи хэлний чадварыг нотлох гэрчилгээ
6. Бусад

Сургуулиасаа хамаараад бүрдүүлэх материал ялгаатай, мөн япон, эсхүл англи хэлээр орчуулж өгөхийг шаардах тохиолдол байдаг тул дэлгэрэнгүйг тухайн сургуулиасаа шууд лавлаарай.

5. Нарийн мэргэшлийн дээд сургууль, богино хугацааны дээд сургууль гэж?

Тодорхой нэгэн мэргэжлээр мэргэжилтэн болоход хэрэгтэй мэдлэг, онол, мөн практик ур чадварын аль алиныг нь эзэмших боломжтой их дээд сургууль, богино хугацааны дээд сургууль юм.

Компаниуд дээр урт хугацаанд дадлага хийх зэргээр баялаг дадлага хийж, мэргэших мэргэжилтэй холбоотой бусад салбарын судалгаа хийх замаар тухайн мэргэжилтэй шууд холбогдох "Өндөр зэрэглэлийн практик ур чадвар", "Сайн бүтээх чадвар"-ыг эзэмшинэ Төгссөний дараа их сургууль болон богино хугацааны дээд сургууль төгссөнтэй ижил "Бакалавр", эсхүл "Богино хугацааны дээд сургуулийн бакалавр"-тай дүйцэх боловсролын зэрэг авах боломжтой.

6. Сургуулиа төгсөхийн тулд?

Дараах болзлыг ханган их дээд сургууль төгсвөл боловсролын зэрэг авна.

※ Сургуулиасаа хамаараад тусгай төгсөх кредит, нөхцөл заах тохиолдол байдаг.

4. Элсэлтийн шалгалтаа магадлаарай!

Ихэнх сургуулиуд япон элсэгчдэд зориулсан элсэлтийн шалгалтаас гадна гадаад хүмүүс (гадаад оюутан)-т зориулсан элсэлтийн шалгалт зохион байгуулдаг. Дараах хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг нэгтгэн сонгон шалгаруулалт хийдэг. Шалгалт авах арга хэлбэр нь сургуулиасаа хамаараад өөр байх тул тухайн сургуулийн элсэлтийн шалгалтын удирдамж зэргээс харж тодруулаарай.

1. Элсэлтийн материалын сонгон шалгаруулалт
2. Мэдлэгийн тест
3. Ярилцлага
4. Богино эссэ, зохион бичлэг
5. Бусад ур чадвар, тухайн мэргэжил хувь хүний зан чанарт тохирох эсэх
6. Японд суралцах шалгалт (EJU)
7. Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT)
8. Элсэлтийн ерөнхий шалгалт



Төрөл	Сурах жил (дундаж)	Кредит	Боловсролын зэрэг	
Их дээд сургууль (факультет)	Ердийн факультет, 4 жилийн эм зүйн анги	4 жил	124 кредитээс дээш	Бакалавр
	Анагаах, шүд судлал, мал эмнэлгийн анги, 6 жилийн эмзүйн анги	6 жил	Анагаах, шүд судлал 188 кредитээс дээш Мал эмнэлэг 182 кредитээс дээш Эм зүй 186 кредитээс дээш	
Богино хугацааны дээд сургууль	2 жилийн анги	-	62 кредитээс дээш	Богино хугацааны дээд сургуулийн бакалавр
	3 жилийн анги	-	93 кредитээс дээш	
Нарийн мэргэшил олгох дээд сургууль	-	4 жил	124 кредитээс дээш	Бакалавр (Нарийн мэргэшил)
Нарийн мэргэшил олгох богино хугацааны дээд сургууль	2 жилийн анги	-	62 кредитээс дээш	Богино хугацааны дээд сургуулийн бакалавр (Нарийн мэргэшил)
	3 жилийн анги	-	93 кредитээс дээш	

※ Хичээл нь эхний болон сүүлийн курст хуваагдсан байдаг нарийн мэргэшлийн дээд сургуулийн эхний курсын сургалтыг дүүргэсэн тохиолдолд "Богино хугацааны дээд сургуулийн бакалавр" (Нарийн мэргэшил)-ын зэрэг авах боломжтой.

АСПИРАНТУР



1. Элсэлтийн шалгуураа магадлаарай!

Дараах шалгуурын аль нэгийг хангасан байх шаардлагатай.

1. Магистрын анги

1. Японы их дээд сургууль төгссөн байх
2. Их Дээд Сургуулийн Үнэлгээ, Боловсролын Зэрэг Олгох Байгууллага (NIAD-QE)-аас бакалаврын зэрэг авсан байх
3. Гадаадад 16 жилийн сургуулийн боловсрол эзэмшсэн байх
4. Гадаадын их дээд сургууль болон түүнтэй дүйцэх сургуулийн 3 жилээс дээш сургалттай курсийг суралцан төгсөж, бакалаврын зэрэгтэй дүйцэхүйц боловсролын зэрэг авсан байх
5. Гадаад улсын их дээд сургуулийн сургалт явуулдаг хэмээн магадлан итгэмжлэгдсэн боловсролын байгууллагын 16 жилийн сургалтыг Японд дүүргэсэн байх
6. Тусгайлан заасан мэргэжлийн сургуулийг төгссөн байх
7. Тухайн сургуулийн аспирантурын элсэлтийн шалгалтаар их дээд сургууль төгссөнтэй дүйцэх боловсролтой хэмээн үнэлэгдсэн, 22 нас хүрсэн байх

2. Докторын анги

1. Японд магистрын зэрэг болон нарийн мэргэшлийн зэрэг авсан байх
2. Гадаадад магистрын зэрэг болон нарийн мэргэшлийн зэрэгтэй дүйцэх боловсролын зэрэг авсан байх
3. Гадаадын их дээд сургуулийн аспирантурын сургалт явуулдаг хэмээн магадлан итгэмжлэгдсэн боловсролын байгууллагыг Японд суралцан төгсөж, магистрын зэрэг, эсвэл нарийн мэргэшлийн зэрэгтэй дүйцэх боловсролын зэрэг авсан байх
4. Их дээд сургууль төгсөөд их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага (гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний газар хамаарна) зэрэгт 2-оос дээш жил судалгаа шинжилгээний ажил хийсэн, элсэхийг хүсч буй аспирантур нь магистрын зэрэгтэй хүнтэй дүйцэхүйц боловсролтой хэмээн хүлээн зөвшөөрсөн байх
5. Аспирантурын элсэлтийн шалгалтаар магистрын зэрэг эсвэл нарийн мэргэшлийн зэрэгтэй хүнтэй дүйцэх боловсролтой хэмээн үнэлэгдсэн, 24 нас хүрсэн байх

3. Докторантур (Анагаах ухаан, шүд эмчилгээ, эм зүйн зарим анги, мал эмнэлгийн анги)

Анагаах ухаан, шүд эмчилгээ, эм зүйн зарим анги болон мал эмнэлгийн ангид элсэхээр хүсэлт гаргах бол боловсролын зэргээсээ хамаараад элсэлтийн шалгуур нь өөр байдаг тул өргөдөл гаргахаасаа өмнө тухайн их дээд сургуулиасаа лавлаарай.

2. Судалгааны төлөвлөгөө бичье!

Судалгааны төлөвлөгөө гэдэг нь тодорхой нэгэн сэдвээр хэрхэн судалгаа хийх вэ гэдгээ илэрхийлж бичсэн зүйл юм. Ихэнх аспирантурт судалгааны ажлын төлөвлөгөө гаргаж өгөхийг шаарддаг.

Агуулга нь дараах байдалтай байна.

1. Судалгааны зорилго
2. Урьдчилсан нөхцөл
3. Ач холбогдол
4. Судалгааны арга зүй
5. Ашигласан материал гэх мэт

Формат болон үг үсгийн тоо нь сургуулиасаа хамаарч өөр байдаг бөгөөд үсгийн тоо нь ерөнхийдөө 2000 орчим (япон хэл дээр) байдаг. Судалгааны төлөвлөгөө бичихийн тулд судалгаа хийх салбарынхаа эрдэм шинжилгээний өгүүллэгүүдийг хайж, энэ чиглэлийн судалгаа хэр хэмжээнд хийгдсэн байна, судлагдаагүй ямар асуудал үлдсэн байна гэдгийг судалж тодруулах нь чухал.

Дараах талыг харж дүгнэдэг.

1. Судалгааны ажилд хандаж буй идэвх
2. Асуудал олох чадвар
3. Асуудал шинжлэх чадвар
4. Логик сэтгэлгээ
5. Мэргэжлийн мэдлэг



● **Судалгааны төлөвлөгөө бичих аргачлал**
Судалгааны ажлын төлөвлөгөө хэрхэн бичих, ярилцлагын шалгалтад хэрхэн бэлдэх талаар мэдэж авч болно.

Гаргасан: JASSO
Хэвлэсэн: Bonjinsha Co., Ltd (Япон улсад борлуулагддаг)

※ Японд суралцах материал, гарын авлагатай танилцах цэг (45-р хуудас харах)-т танилцах боломжтой.

Эрдэм шинжилгээний өгүүлэл хайх



CiNii Articles

<https://ci.nii.ac.jp/en>

З-1. Сургуулиа хайя!

 **Аспирантурт сурах талаархи мэдээлэл (JASSO)**
https://www.jasso.go.jp/en/study_j/search/daigakukensaku.html

 **Аспирантурт сурах сургууль хайх (JAPAN STUDY SUPPORT)**
<https://www.jpss.jp/en/>

З-2. Удирдагч багшаа хайя!

Удирдагч багш нь хичээлийн төлөвлөгөө болон судалгааны ажлыг удирдах бөгөөд удирдагч багшийг үндсэндээ өөрөө хайж олох хэрэгтэй байдаг. Зарим сургуулийн хувьд удирдагч багшаа урьдчилан олж, удирдах зөвшөөрлийг нь авах шаардлагатай.

< Удирдагч багш хайх >

- Төгссөн их сургуулийнхаа удирдагч багшаар дамжуулан олох
- Эрдэм шинжилгээний сэтгүүл, Японд төгсөгчид, өөрийн орны эрдэмтэн судлаачдаас мэдээлэл олж авах
- Вэб хуудас гэх мэт
- Сурахыг хүсч буй сургуулиараа дамжуулан танилцах



Дээд ангийн болон төгссөн оюутнуудын дуу хоолой

Удирдагч багш нь оюутны амьдралын нэг чухал хэсэг. Тиймээс дээд ангийн оюутнуудаас удирдагч багшийн талаар аль болох мэдээлэл авч, өөрт тохирох эсэхээ судлаарай.

4-1. Элсэлтийн материалтай танилцаарай!

Аспирантурын үндсэн ангид шууд шалгалт өгөхийг зөвшөөрдөг сургууль байхад судлаач оюутнаар суралцсаны дараа элсүүлдэг сургууль ч бий.

1. Элсэх өргөдөл (Тухайн аспирантурын маягтаар)
2. Их дээд сургуулийн бакалаврын (төгсөх гэж буйг нотлох) гэрчилгээ
3. Магистрын зэрэг (авах гэж буйг нотлох)-ийн гэрчилгээ (Докторантурт элсэх гэж байгаа бол)
4. Хамгийн сүүлд төгссөн сургуулийн дүнгийн тодорхойлолт
5. Багшийн болон ажлын газрын тодорхойлолт
6. Төгссөн их дээд сургуульд сурч байхдаа бичсэн диссертаци (дипломын ажил) болон түүний агуулгын товч
7. Судалгааны төлөвлөгөө
8. Бусад

Сургуулиасаа хамаарч бүрдүүлэх материал өөр, мөн япон, эсхүл англи хэлний орчуулгын шалгалт өгөх шаардлагатай байх тохиолдол бий тул тухайн сургуулиасаа сайтар тодруулаарай.

Судлаач хайх

 **researchmap**
<https://researchmap.jp/search/?lang=english>

< Багш болон сургуультай холбоо барих тохиолдолд >

Өөрийн хийсэн судалгааны ажлын үр дүн, цаашид хийх судалгааны ажлын төлөвлөгөө, уг багшийг сонгосон шалтгаан зэргээ тодорхой бичиж, болж өгвөл төгссөн сургуулийнхаа удирдагч багшаас тодорхойлолт авч хавсаргах нь зүйтэй. Багш тань зөвхөн өөрийн чинь явуулсан материалд үндэслэн таныг дүгнэх тул сонгосон багштайгаа хэдэнтэй холбоо барьж, өөрийн хүсэл зоригийг ойлгуулах хэрэгтэй.

Багшид мэйл хэрхэн бичих талаар өмнө дурдсан "Судалгааны төлөвлөгөө бичих практик арга зүй"-ээс судалж болно.



Зөвлөгөө

Судлаач оюутан (Research student) гэж хэн бэ?

Судлаач оюутан гэдэг нь дараах үндсэн бус оюутанд олгогддог статус юм.

1. Эрдмийн зэрэг авах зорилгоор бус, богино хугацааны судалгаа шинжилгээний ажил хийхийн тулд суралцаж буй суралцагч (Ихэвчлэн аспирантурын түвшинд)
2. Их дээд сургууль хоорондын солилцооны дагуу богино хугацаагаар суралцаж буй оюутан (Факультет, аспирантур)
3. Аспирантурт элсэхийн тулд бэлтгэл сургалтад суралцаж буй суралцагч (Ихэвчлэн факультет дүүргэсэн хүн)

Шалгаруулалт: Бичиг баримтын шалгаруулалтаар ихэвчлэн шалгаруулж авдаг ч ярилцлага авах тохиолдол ч бий.

Оршин суух статус: Зөвхөн сонсогч оюутнаар "Оюутны" виз авахын тулд долоо хоногт 10-аас илүү цагийн хичээлд суух шаардлагатай. Түүнээс гадна сонсогчийн журмаар биш үнэгүйгээр судалгаа явуулдаг судлаачийн хувьд "Соёлын үйл ажиллагаа" гэсэн оршин суух статус авах шаардлагатай.

4-2. Өргөдөл гаргах хугацаагаа магадлаарай!

6-1 сарын өмнөөс өргөдөл хүлээн авах нь олонтаа. Хичээл нь ихэвчлэн 4 сараас эхлэх бөгөөд 9 болон 10 сард хичээл нь эхэлдэг сургуулиуд ч бий.

4-3. Элсэлтийн шалгалтаа тодруулаарай!

Дараах материал, шалгалтын дүн зэргээс хэд хэдэн үзүүлэлтийг хослуулж сонгон шалгаруулалт хийдэг. Сургуулиасаа хамааран сонгон шалгаруулах арга нь өөр тул тухайн сургуулийн вэб сайт зэргээс тодруулаарай.

1. Бичиг баримтын шалгаруулалт (Гаргасан өргөдөл болон холбогдох бичиг баримт)
2. Мэдлэгийн тест (Мэргэжлийн, эсвэл заасан хичээлийн бичгийн шалгалт)
3. Ярилцлага (Шууд, эсвэл онлайнаар)
4. Богино диссертаци, зохион бичлэг
5. Сонгосон мэргэжлийнх нь дагуу авах ярилцлага (Шууд, эсвэл утсаар)

5. Нарийн мэргэшлийн магистрантур гэж юу болох?

Өндөр зэрэглэлийн мэргэжлийн чадварт сургаж, нийгэм, эдийн засгийн төрөл бүрийн салбарыг авч явах нарийн мэргэшлийн боловсон хүчнийг бэлдэх зорилго бүхий курс юм. Тухайлбал, хуулийн мэргэжилтэн бэлтгэдэг хууль зүйн аспирантур, багшлах боловсон хүчин бэлтгэдэг боловсрол судлалын аспирантур, мөн бизнес, технологийн менежмент, нягтлан бодох бүртгэл, төр олон нийтийн бодлого зэрэг салбаруудад нарийн мэргэшлийн аспирантур байдаг. Англи хэлээр хичээл нь явагддаг бизнесийн удирдлагын магистрын анги ч бий.

6. Төгсөхийн тулд яах вэ?

Анги, курс	Авах боловсролын зэрэг	Суралцах үндсэн хугацаа	Авах кредит	Төгсөх шалгуур
Докторын анги	Доктор	5 жил	30 кредитээс дээш (Магистрантурт авсан кредит багтана)	Докторын диссертаци хамгаалах шалгалтад тэнцэх
Магистрын анги	Магистр	2 жил	30 кредитээс дээш	Магистрын диссертаци хамгаалах шалгалтад тэнцэх
Нарийн мэргэшлийн зэрэг олгох курс	Магистр (нарийн мэргэшил)	2 жил	30 кредитээс дээш	
	Хууль зүйн доктор (нарийн мэргэшил)	3 жил	93 кредитээс дээш	
	Боловсролын магистр (нарийн мэргэшил)	2 жил	45 кредитээс дээш	

* Аспирантур нь магистрын анги (2 жил), докторын анги (3 жил) гэж хуваагддаг.


* Бакалаврын сургалт нь 6 жил үргэлжилдэг анагаах ухаан, шүд судлал, 6 жилийн эм зүйн болон мал эмнэлгийн анги нь магистрын анги байхгүй, докторантурт суралцах үндсэн хугацаа 4 жил байдаг.



АНГЛИ ХЭЛЭЭР БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГ АВАХ АНГИ

Японы их дээд сургууль глобалчлагдаж буйтай уялдан их дээд сургууль болон аспирантурт япон хэл судлалгүйгээр "Зөвхөн англи хэл дээр хичээлээ үзэж боловсролын зэрэг авч болдог хөтөлбөр" шинээр бий болж байна. Гэхдээ техникийн коллеж болон мэргэжлийн сургуульд ийм хөтөлбөр байдаггүй.

1. Сургуулиа хайя!

 **Англи хэлээр боловсролын зэрэг авах боломжтой хөтөлбөр (JASSO)**
https://www.jasso.go.jp/en/study_j/search/daigakukensaku.html

 **Их дээд сургууль, богино хугацааны дээд сургууль хайх (JAPAN STUDY SUPPORT)**
<https://www.jpss.jp/en/>

2. Элсэлтийн материалаа нягтлаарай!

Энгийн бичиг баримт (Хуудас 13, 15)-аас гадна дараах бичиг баримтыг өгөх шаардлагатай байх тохиолдол олон.

- 1) Англи хэлний чадварыг нотлох гэрчилгээ (TOEFL®, IELTS зэрэг албан ёсны шалгалтын дүн)
- 2) Мэдлэг чадварыг тодорхойлох гэрчилгээ (Бакалаврт сурах бол Японд суралцах шалгалт (EJU), SAT, өөрийн орны ахлах сургуулийн улсын шалгалтын дүнгийн тодорхойлолт)

3. Сонгон шалгаруулалтын талаар магадлаарай!

- 1) Бичиг баримтын шалгаруулалт
- 2) Ярилцлага (Таны амьдарч буй улс, бүс нутагт авах ярилцлага, онлайн ярилцлага)
- 3) Бусад

< **Шаардагдах англи хэлний чадварын түвшин** >

	TOEFL iBT	IELTS
Аспирантур	75-80	6
Факультет	71-80	5.5-6

Зөвлөгөө

Япон хэл ч үзмээр байна!

Гадаад оюутанд зориулсан япон хэлний сургалтын хөтөлбөртэй сургууль ч бий. Гэхдээ кредит авах боломжтой болон боломжгүй тохиолдол байдаг. Мөн сургалтын төлбөр төлөх шаардлагатай тохиолдол ч бий.

Дээд ангийн болон төгссөн оюутнуудын дуу хоолой

Зөвхөн англи хэлээр явагдах хичээлд суугаад боловсролын зэрэг авах ангид орсон ч япон хэлний яриа болон хирагана, катакана үзвэл Японд амьдрахад амар хялбар болохоос гадна ажилд орох боломж илүү нээгдэнэ.

Мөн зарим улсын хувьд виз авахад япон хэл үзэж байсан талаар шалгуур тавьдаг тул сургуулиасаа ямар бичиг баримт гаргаж өгөхийг лавлаарай.

Англи хэл дээр явагддаг хичээл (Хэлний хичээл хамаарахгүй)-ийн нийт хичээлд эзлэх хувь өндөртэй 10 сургууль

Байр	Их дээд сургууль	Байршил	%
1	Олон Улсын Боловсролын Дээд Сургууль	Акита муж	98.0%
2	Рицүмэйкан Ази Номхон Далайн Дээд Сургууль	Ооита муж	88.9%
3	Миязаки Олон Улсын Дээд Сургууль	Миязаки муж	40.3%
4	Окагакүэн их сургууль	Айчи муж	30.7%
5	Нагоя худалдааны их сургууль	Айчи муж	26.4%
6	Олон улсын Христийн их сургууль	Токио хот	22.3%
7	Осака Жёгакүин коллеж	Осака хот	18.7%
8	Жёёжи их сургууль	Токио хот	16.0%
9	Кансай гадаад хэлний дээд сургууль	Осака хот	15.9%
10	Хитоцүбаши их сургууль	Токио хот	15.1%

Эх сурвалж: "Дэлхийн их дээд сургуулиудын рейтинг" япон хэл дээрх хувилбарыг үндэслэн муж, хотоор нь гаргав.

Англи хэлээр боловсролын зэрэг авах боломжтой ангийн тоо

Мэргэшил	Факультет	Аспирантур
Хүмүүнлэгийн ухаан	11	25
Нийгмийн ухаан	13	124
Боловсрол судлал	0	8
Байгалийн ухаан	7	214
Инженеринг	17	571
ХАА, ус агнуур, мал эмнэлэг	3	83
Анагаах ухаан, эрүүлийг хамгаалах	1	104
Амьдралын ухаан	0	0
Урлаг судлал	0	8
Нэгдсэн онолын факультет	48	65

Эх сурвалж: Японы Оюутныг Дэмжих Байгууллагын судалгаа (2018 оны 3 сарын байдлаар)

БОГИНО ХУГАЦААГААР СУРАЛЦАХ, ЯВЦЫН ДУНДААС ОРОХ

1. Богино хугацаагаар суралцах талаар тодруулаарай!

Богино хугацаагаар суралцах гэдэг нь боловсролын зэрэг авах зорилгоор бус, хэдэн 7 хоногоос 1 жил хүртэлх хугацаагаар суралцахыг хэлнэ.

Хичээл явагдах хэл: Япон юмуу англи хэл дээр явагдана. Мөн япон, англи хэл дээр хосолсон байдлаар явагдах тохиолдол бий.


Сургалтын хөтөлбөрийн хэлбэр: Богино хугацаагаар суралцах гадаад оюутанд зориулсан тусгай ангитай байх, эсвэл факультетын ердийн хичээлүүдэд сууж суралцах гэх мэт янз бүр байдаг.

Богино хугацаагаар суралцах нь дараах 5 онцлогтой.

	Агуулга	Кредит	Сургалтын төлбөр хаана төлөх	Хаанаас лавлах
1. Оюутан солилцоогоор суралцах	Оюутан солилцох гэрээтэй их дээд сургуульд суралцах тогтолцоо	Тухайн гадаадын сургуульд суралцах хугацаандаа авсан кредитийг оюутан солилцооны гэрээний дагуу үндсэн сургуулийн кредитээр хүлээн зөвшөөрдөг.	Үндсэн сургуульдаа. (Оюутан солилцоогоор суралцах гадаад сургуулийн төлбөрөөс чөлөөлөгдөнө.)	Өөрийн оронд одоо суралцаж буй сургууль
2. Оюутан солилцооноос бусад хөтөлбөрүүд	Оюутан солилцооны гэрээтэй сургуулиас бусад сургуулийн оюутнууд ч суралцаж болох хөтөлбөр бий	Хөтөлбөрөөсөө хамааран кредит авч болох болон болохгүй тохиолдол бий.	Суралцах гадаадын сургууль	Очиж суралцах Японы их дээд сургууль
3. Судлаач оюутан ^{*2}	Их дээд сургууль төгссөн хүн бол "Судлаач оюутан"-аар 6 сар, эсвэл 1 жил аспирантурт мэргэжлийн судалгаа хийж болдог тогтолцоо юм.	Авах боломжгүй	Суралцах гадаадын сургууль	Суралцах Японы их дээд сургууль
4. Сонсогч оюутан ^{*2}	Хичээлд сууж, сонсох зорилготой тогтолцоо	Авах боломжгүй	Суралцах гадаадын сургууль	Суралцах Японы их дээд сургууль
5. Судлагч оюутан ^{*2}	Кредит авах зорилго бүхий тогтолцоо	Авах боломжтой.	Суралцах гадаадын сургууль	Суралцах Японы их дээд сургууль

*1 Богино хугацааны хөтөлбөртэй их дээд сургууль хайх (JASSO)
https://www.jasso.go.jp/ryugaku/study_j/search/daigakukensaku.html

*2 Судлаач оюутан, сонсогч ба судлагч оюутан гэсэн статусаар "Оюутны виз" авахын тулд аль аль нь "1 долоо хоногт 10-аас дээш цагийн хичээлд суух ёстой" гэж хуульд заасан байдаг.



Q Богино хугацаагаар суралцахад тэтгэлэг байдаг уу?

A Дараах тэтгэлэг бий.

1. Японы Засгийн Газар (БШУЯ)-ын япон хэл, соёл судлаач оюутанд зориулсан тэтгэлэг

Хэн хамрагдах: Их дээд сургуулийн факультетын оюутан бөгөөд япон хэл, соёлын чиглэлээр мэргэшиж буй оюутан
Тэтгэлгийн хэмжээ (Сард): 117,000 йен
Хаанаас лавлах: 1) ЭСЯ-ны тодорхойлолтоор: Өөрийн оронд буй Япон улсын Дипломат Төлөөлөгчийн Газар, 2) Их сургуулийн тодорхойлолтоор: Одоо сурч буй сургууль

2. Японы Оюутныг Дэмжих Байгууллага (JASSO)-ын Оюутан Солилцоог Дэмжих Хөтөлбөр (Гэрээний дагуу хүлээн авна)-ийн тэтгэлэг

Хэн хамрагдах: Их дээд сургууль хоорондын оюутан солилцооны гэрээгээр суралцах оюутан
Тэтгэлгийн хэмжээ (Сард): 80,000 йен
Хаанаас лавлах: Өөрийн орон дахь сурч буй сургууль

2. Явцаас орох болон шилжиж орох талаар тодруулаарай!

Явцын дундаас орох, шилжиж орохыг зөвшөөрдөг их дээд сургууль олон байдаг ч хэрэгжилт нь дор дурдсанчлан янз бүр байдаг.

- Жил бүр оюутан хүлээж авах албагүй.
- Бүх факультет, ангиудад явцын дундаас орох, шилжин орохыг зөвшөөрдөггүй.
- Өмнөх суралцсан жил болон авсан кредитийг тань хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол бий.

Их дээд сургууль (факультет)-д явцын дундаас орох болон шилжин орохын тулд дараах болзлын аль нэгийг хангасан байх шаардлагатай.

- Богино хугацааны дээд сургууль, техникийн коллеж төгссөн байх, техникийн мэргэжилтэн цолтой байх, ахлах сургуулийн нэмэлт мэргэжлийн ангийг төгссөн байх
- Их дээд сургуулийн үндсэн ангид 1 жилээс дээш хугацаагаар суралцаж, заагдсан кредитийг авсан байх, 4 жилийн их дээд сургууль төгссөн байх

Явцын дундаас орох, шилжин орох тогтолцооны талаарх мэдээлэл нь ердийн элсэлтийн шалгалтын мэдээлэлтэй харьцуулахад цөөн байдаг. Тиймээс нарийн мэдээллийг элсэхийг хүсч буй сургуулиасаа эртнээс шууд лавлаж тодруулаарай.

i Явцын дундаас орох, шилжиж орохыг зөвшөөрдөг их дээд сургууль хайх (JASSO)
https://www.jasso.go.jp/en/study_j/search/daigakukensaku.html

ТЕХНИКИЙН КОЛЛЕЖ

Техникийн коллеж нь "高専 - Коосэн" хэмээн нэрлэгддэг дээд боловсролын байгууллага юм. Дунд сургууль төгссөний дараа 5 жил (худалдааны хөлөг онгоцны анги бол 5 жил хагас)-ийн сургалт тасралтгүй явуулдаг. Гадаад оюутныг 3-р курсээс элсүүлдэг. Улсын техникийн коллеж нь Японд нийтдээ 51, оюутны хотхон 55 бий. Үүнээс гадна хот, мужийн болон хувийн техникийн коллежууд ч мөн бий.

1. Сургалтын онцлог нь юу вэ?

- Дэвшилтэт онолд тулгуурласан туршилт, дадлага, семинар голчилсон сургалтаар дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн ур чадварт суралцаж, сүүлийн үеийн шинжлэх ухаан технологитой шууд харьцаж чадах практик ур чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэх байгууллага юм.
- Ихэнх анги нь инженерийн анги байдаг бөгөөд хөлөг онгоцны ажилчин бэлдэх худалдааны хөлөг онгоцны анги бас бий.
- 5 жилийн сургалтаас гадна илүү өндөр зэрэглэлийн боловсрол олгох 2 жилийн нарийн мэргэшил олгох анги бас бий.
- Нарийн мэргэшлийн ангийг төгсөж, Их Дээд Сургуулийн Шинэчлэл, Боловсролын Зэрэг Олгох Байгууллага (NIAD-QE: National Institution for Academic Degrees and University Evaluation)-ын шүүлтээр орж тэнцвэл "Бакалавр"-ын зэрэг авах боломжтой.

2. Явцаас орох шалгуурыг тодруулаарай!

Аль нэг шалгуурыг хангасан байх шаардлагатай.
(Улсын техникийн коллежийн хувьд)

1. Гадаадад 11 жилийн сургуулийн боловсрол дүүргэсэн, эсвэл дүүргэх гэж буй хүн
 2. Гадаадад 11 жилийн сургуулийн боловсрол эзэмшсэнтэй дүйцэх боловсролтой болохыг нотлох шалгалтад тэнцсэн, эсвэл тэнцэх гэж буй хүн
 3. Гадаад улсын ахлах сургуультай дүйцнэ гэж магадлан итгэмжлэгдсэн Япон дахь гадаад сургуулийг суралцан төгссөн, эсвэл төгсөх гэж буй хүн
 4. Олон улсын бакалавр, абитур, Францын бакалавр зэрэгтэй байх
 5. Япон дахь олон улсын үнэлгээний байгууллага болох "WASC, CIS, ACSI"-аар магадлан итгэмжлэгдсэн гадаад сургуулийн 11 жилийн боловсролыг дүүргэсэн байх
 6. Ахлах сургууль төгссөнтэй дүйцэх боловсрол эзэмшсэнийг батлах шалгалтад тэнцсэн байх
 7. Сургуулийн боловсролын хуулинд заагдсан дээрхээс бусад элсэх шалгуурын аль нэгийг хангасан байх
 8. Ахлах сургууль төгссөнтэй дүйцэх сурах чадвартай гэдэг нь тогтоогдсон байх
- ※ 1-3-ын хувьд 11 жилийн боловсрол хүрэхгүй тохиолдолд БШУС-ын заасан бэлтгэл сургалтын курс, эсхүл сургалтын байгууллагад сургалтанд хамрагдаж дүүргэсэн байх шаардлагатай.

З-1. Улсын зардлаар сурах тохиолдолд

Япон улсын Засгийн Газар (БШУЯ)-ын тэтгэлгээр сурах техникийн коллежийн оюутан

Хаанаас лавлах: Өөрийн орон дахь Япон улсын ЭСЯ

З-2. Хувийн зардлаар сурах тохиолдолд


1 Элсэлтийн материал

Үндэсний Технологийн Институт нь Японы техникийн коллежийн элсэлтийн нэгдсэн шалгалтыг зохион байгуулдаг тул элсэх үед бүрдүүлэх материал адил байдаг. Дэлгэрэнгүйг тус байгууллагын вэб сайтаас үзээрэй.

2 Элсэлтийн шалгалт


Үндэсний Технологийн Институт нь дараах үзүүлэлтийг ерөнхийд нь үнэлэн дүгнэж, тэнцүүлэх эсэхээ шийдвэрлэдэг.

1. Элсэлтийн материал
2. Японд суралцах шалгалт (EJU)-ын дүн
3. TOEFL®, IELTS, TOEIC® шалгалтын аль нэгнийх нь дүн
4. Ярилцлагын шалгалтын үнэлгээ (Ярилцлагын шалгалтыг Японд өгөх шаардлагатай.)

 **Үндэсний Технологийн Институтын Олон Улсын Харилцааны Төв**
<http://www.kosen-k.go.jp/english>

4. Төгссөнийхөө дараа яах вэ?

Технологийн коллеж төгссөний дараа ажилд орох, дэвшин суралцахын аль нэгийг сонгож болно. Ажил хайгчдад нэртэй 20 гаруй компаниас ажлын санал ирэх тохиолдол бий. Олонх төгсөгчид техникийн коллежид эзэмшсэн мэдлэг, ур чадвараа ашиглан судалгаа хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн менежмент, үйлдвэр зэрэгт ажилладаг. Улсын их сургуульд явцын дундаас орж суралцах гадаад оюутнууд олон байдаг.



※ Гадаад оюутан техникийн коллежийн 3-р курсээс гол төлөв элсэн орж суралцдаг

МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛЬ (ТМС-ИЙН МЭРГЭЖИЛ ОЛГОХ КУРС)

Техник мэргэжлийн сургуулиуд дотроос мэргэжлийн сургалтын анги бүхий дээд боловсролын байгууллагын нэг бөгөөд мэргэжлийн сургууль гэж дуудагддаг. Ажил, амьдралд шаардлагатай мэдлэг, технологи, ур чадварт суралцаж, боловсролоо дээшлүүлэх явдлыг зорилгоо болгосон дээд боловсролын байгууллага юм. "Техникийн мэргэжилтэн"-ий цол авах боломжтой, 2-оос дээш жил суралцах ангиас гадна илүү өндөр мэргэжлийн ур чадвар олгох зорилго бүхий "Нарийн техникийн мэргэжилтэн"-ий цол авах боломжтой, 4-өөс дээш жил суралцах анги ч бий.

1. Сургалтын онцлог нь юу вэ?

Мэргэжлийн сургууль нь 1) Эмчилгээ, 2) Аж үйлдвэр, 3) Соёл боловсрол, 4) Худалдаа, 5) Ариун цэвэр эрүүл ахуй, 6) Боловсрол нийгмийн халамж, 7) Хувцасны дизайнер, 8) ХАА гэсэн 8 том салбарт хуваагддаг.

Тухайлбал, дараах ажилд ороход шаардлагатай зүйлсийг эндээс судлах боломжтой.

Интерьер дизайнер, архитектор, систем инженер, машин засварчин, сувилагч, шим тэжээл судлаач, тогооч, нарийн боов үйлдвэрлэгч, гоо сайханч, мэргэшсэн нягтлан бодогч, орчуулагч, онгоцны үйлчлэгч, зочид буудлын ажилтан, цэцэрлэгийн багш, гэрийн асрагч, хувцасны дизайнер, анимэ артист, кино найруулагч, жүжигчин, тоглоом зохион бүтээгч, гоёл чимэглэлийн дизайнер гэх мэт

2. Япон хэлний ямар түвшин шаардагдахыг магадлаарай!

Мэргэжлийн сургуулийн хичээл япон хэл дээр явагддаг тул япон хэлтэй байх шаардлагатай.

Дараах шалгуурын аль нэгийг хангасан байх шаардлагатай.

1. Хууль зүйн сайдын зөвшөөрөлтэй Япон хэлний сургалтын байгууллагын сургалтад 6 сараас дээш хугацаагаар хамрагдсан байх
2. Японы Олон Улсын Боловсролыг Дэмжих Холбоо, Олон Улсын Солилцооны Сангийн зохион байгуулдаг япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT) -ын N1 болон N2 түвшинд тэнцсэн байх
3. Японы бага, дунд, ахлах сургуульд нэг жилээс дээш хугацаанд суралцсан байх
4. Японд суралцах шалгалт (EJU) (Япон хэл: унших болон сонсох, унших сонсох шалгалтын нийт оноо)-д 200-аас дээш оноо авсан байх
5. Япон Хэлний Ханз Үсгийн Чадвар Тогтоох Холбооноос зохион байгуулдаг ВЈТ “Бизнесийн япон хэлний чадварын тест”-д 400-аас дээш оноо авсан байх

3. Элсэлтийн шалгуур хангасан эсэхээ магадлаарай!

Доорхи аль нэг шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай.

1. Гадаад улсад 12 жилийн сургуулийн боловсрол эзэмшсэн байх
 2. Гадаад улсад 12 жилийн сургуулийн боловсрол эзэмшсэнтэй дүйцэх боловсрол эзэмшсэнийг батлах шалгалтад тэнцсэн, 18 нас хүрсэн байх
 3. Гадаад улсын ахлах сургуультай дүйцнэ гэж магадлан итгэмжлэгдсэн гадаад иргэдийн сургуулийг Японд суралцан төгссөн, 18 нас хүрсэн байх
 4. Гадаад улсад Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын хүлээн зөвшөөрсөн 11-ээс дээш жилийн сургуулийн боловсролыг дүүргэсэн байх
 5. Олон улсын бакалавр, Германы абитур, Францын бакалавр зэрэгтэй, эсхүл GCE A түвшний шалгалтанд тухайн сургуулийн заасан дүнг авсан байх
 6. Япон дахь олон улсын үнэлгээний байгууллага болох “WASC, CIS, ACSI”-ийн магадлан итгэмжилсэн гадаад иргэдийн сургуульд 12 жилийн боловсрол эзэмшсэн байх
 7. Ахлах сургууль төгссөнтэй дүйцэх боловсрол эзэмшсэнийг батлах шалгалтад тэнцсэн, 18 нас хүрсэн байх
 8. Тухайн сургуулийн элсэлтийн тусгай шалгалтаар ахлах сургууль төгссөнтэй дүйцэхүйц сурах чадвартай нь тогтоогдсон, 18 нас хүрсэн байх
 9. Сургуулийн боловсролын хуулинд заасан дээрх шалгуураас гадна тухайн сургуулийн бусад шалгуурын аль нэгийг хангасан байх
- ※ 1.-3.-ын хувьд суралцсан хугацаа 12 жил хүрэхгүй бол заагдсан бэлтгэл сургалт болон сургалтын байгууллагад суралцаж төгсөх шаардлагатай.



4. Сургуулиа хайя!

Мэргэжлийн сургууль сонгохдоо анхаарах зүйлс!

1. Албан ёсны зөвшөөрөлтэй сургууль эсэх	Харьяалагдах хот, мужийн засаг даргын зөвшөөрөлтэй эсэх, зөвшөөрөлгүй сургуулиас “Мэргэжилтэн” цол авах боломжгүй.
2. Сургалтын агуулга, багшийн тоо	Сурахыг хүсч буй мэдлэг, чадвар эзэмшихүйц сургалтын хөтөлбөртэй эсэх, багш оюутны тооны харьцаа
3. Сургалтын орчин, материаллаг бааз	Сургалтын орчин болон материаллаг бааз нь суралцагчийн техник, ур чадварыг хөгжүүлж чадах түвшинд байгаа эсэхийг фото альбом, танилцуулга зэргээс үзэж нягтлах
4. Ажилд орох зөвлөгөө өгдөг эсэх, төгсөгчдийн замнал	Ажилд орох зөвлөгөө өгөхөд баримтлах зарчим нь ямар болох, төгсөгчид хаана ажилд орж байна, хүссэн ажилдаа орох боломжтой эсэх
5. Сургалтын төлбөр	Эхний жилийнх хэд болох, төгсөх хүртэлх сургалтын нийт төлбөр хэд болох, хэзээ төлөх
6. Эргэн тойрны хүмүүсийн үнэлэлт	Төгсөгчид болон гадаад оюутнуудын нэвтрэх зэргээ ашиглаарай.



Зөвлөгөө

Төгсөх болзолтой танилцах

Мэргэжилтэн цол авах боломжтой анги эсэх талаар сургуулиасаа тодруулаарай.

i Мэргэжлийн сургууль хайх (Metropolitan Tokyo Professional Institution Association)
<https://tsk.or.jp/?language=en>

i Гадаад оюутан авч сургадаг мэргэжлийн сургуулийн жагсаалт (Мэргэжлийн Сургалт, Карьер Сургалтын Холбоо)
<http://www.sgec.or.jp/ryuugakuguide/en/index.html>

5. Ямар материал бүрдүүлэхээ нягтлаарай!

1. Сургуульд элсэх өргөдөл (Тухайн сургуулийн маягтаар)
2. Ахлах сургуулийн төгсөлтийн гэрчилгээ
3. Хамгийн сүүлд төгссөн сургуулийн дүнгийн тодорхойлолт
4. Япон хэлний сургалтын байгууллагын ирц болон дүнгийн тодорхойлолт (Японд амьдарч байгаа бол)
5. Япон хэлний чадварыг гэрчлэх гэрчилгээ (Гадаадад амьдарч байгаа бол)
6. Бусад

Сургуулиасаа хамааран бүрдүүлэх материал өөр байдаг, мөн япон эсвэл англи хэлээр орчуулж гаргаж өгөхийг шаардах тохиолдол байдаг тул энэ талаар элсэхийг хүссэн сургуулиасаа тодруулаарай.

6. Элсэлтийн шалгалтын талаар тодруулаарай!

1) Бичиг баримтын шалгаруулалт, 2) Мэдлэгийн тест, 3) Ярилцлагын шалгалт, 4) Зохион бичлэг, 5) Тухайн мэргэжил хувь хүний зан төрхөд тохирох эсэхийг тогтоох тест, 6) Ур чадварын шалгалт, 7) Япон хэлний шалгалт зэргээс хэд хэдэн шалгалт, үзүүлэлтүүдийг хослуулан авч, сонгон шалгаруулалт хийдэг.

Элсэлтийн шалгаруулалтыг хийхдээ ямар ч ангийн хувьд 1-рт Зорилгоо ухамсарласан байдал, 2-рт Элсэж орсны дараа хичээлээ ойлгож гүйцэж чадахуйц япон хэлний чадвар болон суралцах чадвартай эсэх, 3-рт Сурах хүсэл эрмэлзэл зэргийг голчлон үздэг.

7. Техникийн мэргэжилтэн болон техникийн нарийн мэргэжилтэний ялгаа

	Техникийн мэргэжилтэн	Техникийн нарийн мэргэжилтэн
1. Суралцах жил	2-оос дээш жил	4-өөс дээш жил
2. Хичээллэх цаг	1,700 цагаас дээш	3,400 цагаас дээш
3. Төгсөх зөвшөөрөл	Шалгалтын дүн зэргээр нь үнэлж, тухайн курсыг төгсөх зөвшөөрөл олгоно.	
4. Сургалтын агуулга бүтэц	-	Сургалт нь харилцан уялдаатай, цогц байдалтай байх
5. Төгссөний дараах замнал	Мэргэжилтэн болсон тохиолдолд их дээд сургуульд явцын дундаас орохыг хүлээн зөвшөөрдөг.	Нарийн мэргэжилтэн болсон тохиолдолд аспирантурт орохыг хүлээн зөвшөөрдөг.

ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Гадаад хүмүүст япон хэл заадаг сургалтын байгууллага юм. Японы дээд боловсролын байгууллагын ихэнх ангиуд үндсэндээ япон хэлээр хичээлээ явуулдаг.

Япон хэлний түвшин тогтоох шалгалтын N1, N2 түвшинг хангаснаар япон хэлээр хичээлээ ойлгох боломжтой болно. Эдгээр нь япон хэлийг 600-900 цаг хүртэл судалсан түвшин юм. Сургалтын орчин болон хувь хүний хичээл зүтгэлээс шалтгаалах хэдий ч япон хэл эрчимтэй үзэхэд дор хаяж 1-2 жил шаардлагатай.

1. Сургуулийн төрөл болон тоог магадлаарай!

Япон хэлний сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч болон зорилго, элсэх шалгуур зэргээс нь хамааруулан дараах байдлаар ангилна. Оршин суух зөвшөөрөл болон сургуулийн тоо, суралцагчийн тоо дараах байдалтай байна.

	Япон хэлний сургууль		Хувийн их дээд болон богино хугацааны дээд сургуулийн гадаад оюутанд зориулсан тусгай сургалт ^{*1}
Байгуулсан этгээд	Хуулийн этгээдийн статустай сургууль (Мэргэжлийн сургууль, бусад сургуулиуд), олон нийтийн ашгийн төлөөх сангууд, хувьцааг компани, сайн дурын байгууллага, хувь хүмүүс гэх мэт		Хувийн их дээд болон богино хугацааны дээд сургууль
Зорилго	1. Япон хэл сурах ^{*1} 2. Дэвшин суралцахад шаардлагатай япон хэл заах	2. Дэвшин суралцах зорилгоор япон хэл сурах	1. Япон хэл сургах 2. Дэвшин суралцуулах зорилгоор япон хэл сургах
Элсэх шалгуур	12 жилийн дунд боловсрол эзэмшсэн байх	12 жил хүрэхгүй дунд боловсрол эзэмшсэн бол ^{*2}	А. 12 жилийн дунд боловсрол эзэмшсэн байх
Тоо	564		60
Сургалтын хугацаа	1-2 жил (Ерөнхийдөө)		1-2 жил
Оршин суух зөвшөөрөл	Сурах ^{*3}		Сурах

*1 Өдөр тутмын амьдралд хэрэгтэй япон хэл болон бизнесийн япон хэл үзэж болох курс ч байдаг.

*2 Тухайн орны боловсролын тогтолцооноос хамаарч 12 жилийн албан ёсны боловсрол эзэмшээгүй бөгөөд хамгийн сүүлд ахлах сургууль төгссөн, тусгайлан заасан сургалтыг дүүргээгүй бол Японы их дээд сургуульд элсэн сурах болзлыг хангаагүйд тооцно. Энэ тохиолдолд Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын заасан “Junbi Kyoiku Katei” хэмээх их дээд сургуульд орох бэлтгэл сургалтанд хамрагдаж, 18 нас хүрсэн бол их дээд сургуульд элсэн орох болзлыг хангасан гэж үзнэ.

Бэлтгэл сургалтаар япон хэлнээс гадна их дээд сургуульд элсэхэд өгөх шаардлагатай англи хэл, математик, нийгэм, байгалийн ухаан зэрэг суурь мэдлэгийн хичээлүүдийг мөн заадаг.

*3 "Сурах" гэсэн оршин суух зөвшөөрөл авах боломжтой сургууль нь Хууль Зүйн Сайдын зөвшөөрсөн япон хэлний сургуулиуд юм.

*4 Тусгай анги дотроос гадаад оюутнуудад япон хэл заах тусгай курс нь Гадаад оюутанд зориулсан тусгай сургалт “Ryugakusei Bekka”, эсхүл “Nihongo Bekka” хэмээн дуудагддаг бөгөөд хувийн хэвшлийн их дээд болон богино хугацааны дээд сургуулиудад явагддаг сургалт юм. Энэхүү ангид япон хэл соёл, Япон орон судлал, их дээд сургуульд элсэн ороход шаардлагатай үндсэн хичээлүүдийг үзэх боломжтой. Их дээд сургуульд элсэх хүсэлтэй хүмүүсийн хувьд ийм тусгай сургалттай их дээд сургуульд сургуулийн тодорхойлолтоор элсэн орж болохоос гадна өөр их дээд сургуульд ч элсэн суралцах боломжтой. Их дээд сургуулийн сургалтын орчин, үйлчилгээг ашиглах боломжтойгоороо давуу талтай.

2. Өргөдөл гаргах, элсэх хугацаагаа магадлаарай!

4 сарын элсэлт	10 сарын элсэлт	
4-9 сар	10-2 сар	Өргөдөл авах, бичиг баримт бэлдэх, шуудангаар илгээх
9-11 сар	2-4 сар	Өргөдөл гаргах хугацаа
1-3 сар	7-9 сар	Япон улсын хилээр нэвтрэх бүрдүүлэлт, сургуульд элсэх процедур
4 сар	10 сар	Хичээл эхэлнэ.

Үүнээс гадна 7 болон 1 сард хичээл нь эхэлдэг цөөн хэдэн сургууль мөн байдаг. Дор хаяж 6-9 сарын өмнө бэлтгэлээ хийж эхлээрэй.



З. Элсэлтийн материалаа магадлаарай!

1. Элсэх өргөдөл
2. Хувийн намтар
3. Ахлах болон их дээд сургуулийн дүнгийн тодорхойлолт
4. Ахлах болон их дээд сургуулийн төгсөлт (хэзээ төгсөх талаарх тодорхойлолт)-ийн гэрчилгээ
5. Төлбөрийн чадварыг тодорхойлсон баримт
6. Бусад материал



Зөвлөгөө

Сургууль шилжиж болох уу?

Ерөнхийдөө япон хэлний сургалтын байгууллага хооронд шилжин сурах боломжгүй. Тиймээс тухайн сургуулийн вэб сайт болон танилцуулга, журамтай танилцах, одоо сурч буй болон төгссөн оюутнуудаас шууд асууж лавлах зэргээр мэдээлэл сайтар цуглуулж, сургуулиа ул суурьтай сонгоорой.

Бүрдүүлж өгсөн материалыг голчлон үзэж шалгаруулалт хийдэг хэдий ч сургуульд элсэхийг хүсэгч болон түүний эцэг эх, асран хамгаалагчаас ярилцлага болон бичгийн шалгалт авах тохиолдол бий.

4. Сургуулиа хайя!

Япон хэлний сургалтын байгууллага сонгохдоо анхаарах зүйлс!

1. Сурах виз	Хууль Зүйн Яамны мэдэгдлийн шаардлагыг хангасан байна уу? (Хангаагүй тохиолдолд оюутны виз гарахгүй.)
2. Суралцах зорилго	Өдөр тутмын ярианы хэлтэй болмоор байна уу? Их сургуульд дэвшин суралцах юм уу? Бизнесийн япон хэлтэй болох юм уу?
3. Анги бүрдүүлэлт	Япон хэлний түвшингээр ангилж сургалт явуулж байна уу? Нэг анги хэдэн оюутантай байна?
4. Оюутны тоо, багш ажилтны тоо	Сургуулийн цар хүрээ, оюутан болон багш ажилтны тооны харьцаа ямар болох
5. Аль улсын оюутнууд олон байна?	Ханз үсэгтэн улсын оюутнууд олон байна уу, ханз үсэг хэрэглэдэггүй улсаас ирсэн оюутнуудад санаа тавьж байна уу?
6. Хичээлийн цагийн тоо	Хичээлийн цагийн нийт тоо болон хичээл тус бүрийн цаг хэд болох
7. Шалгалтад бэлдүүлдэг эсэх	Японд суралцах шалгалт (EJU), Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT)-д бэлдүүлдэг эсэх, англи хэл, математик, байгалийн ухаан, дэлхийн түүх, газар зүй зэрэг суурь хичээл заадаг эсэх
8. Карьер болон амьдралын зөвлөгөө	Карьерын болон амьдрал ахуйн талаар зөвлөгөө өгдөг эсэх
9. Өмнө нь төгссөн оюутнуудын замнал	Өмнө нь төгссөн оюутнууд ямар сургуульд дэвшин суралцсан бол? Хүсч буй сургуульдаа явж чадах эсэх
10. Сургалтын төлбөр	Төлбөр нь хичээлийн цагийн болон багшийн тоо, сургалтын орчин, материаллаг баазтай дүйцэж буй эсэх, сургуулиас гарах тохиолдолд төлбөр буцаж ирэх эсэх
11. Элсэлтийн шалгалт	Сонгон шалгаруулалтыг зөвхөн бүрдүүлсэн материалд тулгуурлан хийдэг эсэх, баглан даагч болон Японд амьдардаг холбоо барих хүнээс ярилцлага авдаг эсэх, Япон улсаас өөр газарт сонгон шалгаруулалт явуулдаг эсэх
12. Сургуулийн байршил	Том хотод байрладаг уу, эсхүл хөдөө юу? Цаг уур нь тохирох эсэх
13. Орон байр	Сургуулийн дотуур байртай эсэх, түрээсийн байр танилцуулдаг эсэх

А. Хувийн их дээд сургууль, богино хугацааны дээд сургуулийн дэргэдэх гадаад оюутанд зориулсан тусгай сургалт



Хувийн их дээд сургууль, богино хугацааны дээд сургуулийн дэргэдэх гадаад оюутанд зориулсан тусгай сургалтуудын жагсаалт (JASSO)
https://www.jasso.go.jp/en/study_j/search/nihongokyouiku.html

В. ХЗЯ-ны зөвшөөрөлтэй япон хэлний сургууль (Оюутны виз гарна.)



ХЗЯ-ны зарласан сургуулиудын жагсаалт (ХЗЯ)
http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/nyukan_nyukanho_ho28-2.html



ХЗЯ-ны зарласан япон хэлний сургалтын байгууллага дахь сургалтын бодит байдал (БШУЯ)
http://www.mext.go.jp/a_menu/koutou/ryugaku/1382482.htm



Япон хэлний сургалтын байгууллага хайх (Япон хэлний Боловсролыг Дэмжих Нийгэмлэг)
<https://www.nisshinkyō.org/english/index.html>



Япон Хэлний Сургуулиудын Холбоо (JaLSA)
<http://www.jalsa.jp/>



БШУС-ын заасан "Бэлтгэл шатны сургалт" (JASSO)
https://www.jasso.go.jp/en/study_j/search/nihongokyouiku.html

С. ХЗЯ-ны зөвшөөрөлгүй япон хэлний сургууль (Оюутны виз гарахгүй.)



Зөвлөгөө

Англиар сурах курс байдаг уу?

Англиар сурах курс ч олширч байгаа (Хуудас 17-ын Англи хэл дээр боловсролын зэрэг авах курсыг харар).

Англи хэлээр боловсролын зэрэг авах курс (JASSO)
https://www.jasso.go.jp/en/study_j/search/daigakukensaku.html

ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)



Японд суралцах шалгалт (EJU) нь Японы их дээд сургууль (факультет)-д элсэн суралцах хүсэлтэй хүмүүсийн япон хэлний мэдлэг болон үндсэн мэдлэг (байгалийн ухаан, ерөнхий эрдэм, математик)-ийг тогтоох шалгалт юм.

Японд суралцах шалгалтын дүн ашигладаг сургуулийн тоо

Их дээд сургууль	451
Богино хугацааны дээд сургууль	90
Аспирантур	67
Техникийн коллеж	51
Мэргэжлийн сургууль	146
Нийт	805

(2018 оны 12 сарын байдлаар)



Японы ихэнх их дээд сургуулиуд (Улсын их дээд сургуулийн бараг бүгд) элсэлтийн шалгалтандаа Японд суралцах шалгалтын дүнг харгалздаг.

Нэг сургууль хэрнээ факультетын онцлогоос шалтгаалаад элсэлтийн шалгалтандаа Японд суралцах шалгалтын дүнг харилцан адилгүй ашигладаг тул элсэхийг хүсч буй факультетад тус шалгалтыг өгөх шаардлагатай эсэхийг доорх вэбсайтаас тодруулаарай!



Элсэлтийн шалгалтандаа Японд суралцах шалгалтын дүнг ашигладаг сургуулиуд

https://www.jasso.go.jp/en/study_j/eju/examinee/use/

1. Шалгалтыг хэзээ авдаг вэ?

Жилд 2 удаа зохион байгуулагддаг.

Эхний удаагийнх: 6 сар

2 дахь удаагийнх: 11 сар

2. Шалгалтыг хаана авдаг вэ?

Японд: 16 хот; Гадаадад: 14 улс, бүс нутаг, 18 хот

Японд суралцах шалгалт (EJU) авдаг хотууд (Японоос бусад газар): Энэтхэг (Нью-Дели), Индонез (Жакарта, Сурабая), Солонгос (Сөүл, Пүсан), Шриланка (Колонбо), Сингапур, Тайланд (Бангкок, Чинмай), Тайвань (Тайхоку), Филиппин (Манила), Вьетнам (Ханой, Хочмин), Хонконг, Малайз (Күалаланпур), Мьянмар (Янгон), Монгол (Улаанбаатар), Орос (Владивосток)

3. Ямар хичээлээр шалгалт авдаг вэ?

Элсэхийг хүсч буй сургуулийнхаа заасан хичээлүүдийг сонгож өгнө. Байгалийн ухаан, ерөнхий эрдмийн хичээлийг давхардуулан сонгох боломжгүй.

Шалгалт авах хичээл	Зорилго	Хугацаа	Оноо	Шалгалт өгөх хичээл сонгох	Шалгалт авах хэл
Япон хэл	Японы их дээд сургуульд суралцахад шаардлагатай япон хэлний түвшин (Академик япон хэл)-г тогтооно.	125 мин	Унших, сонсох-унших 0-400 оноо Бичгийн шалгалт 0-50 оноо		Зөвхөн япон хэл
Үндсэн мэдлэг	Байгалийн ухаан	80 мин	0-200 оноо	Физик, хими, биологоос 2 хичээл сонгож өгнө.	Япон эсвэл англи хэл (сонгох)
	Ерөнхий эрдэм	80 мин	0-200 оноо		
	Математик	80 мин	0-200 оноо	Курс 1 (Нийгмийн ухааны факультет болон математикийн мэдлэг шаардагдах нь харьцангуй бага байгалийн ухааны факультет), Курс 2 (Математикийн мэдлэг дээд түвшинд шаардагдах факультет)-ийн аль нэгийг сонгоно.	

(Жишээ) А их сургуулийн гадаад оюутан элсүүлэх журам (EJU шалгалт өгөхийг заасан байдал)

Факультет	Япон хэл	Ерөнхий эрдэм	Математик	Байгалийн ухаан				Үндсэн мэдлэгийн шалгалт авах хэл	Хүчинтэй дүн
				Физик	Хими	Биологи	Хичээл сонгох		
Хуулийн факультет	○	○	Курс 1					Япон хэл	2019 оны 6 сар болон 11 сарын шалгалтын дүн
Инженерийн факультет			Курс 2	○			Өөр нэг хичээл нэмж сонгоно	Англи хэл	2019 оны 6 сарын шалгалтын дүн

4. Шалгалтын хуваариа хараарай!

	Эхний ээлжийн шалгалт	2 дахь ээлжийн шалгалт		
1.	Өргөдөл гаргана.	2-3 сар	7 сар	Шалгалт өгөгч нь өргөдөл гаргах үедээ заасан арга *1-ийн дагуу бүртгүүлж, шалгалтын хураамж төлнө. (Өргөдөл гаргах хугацаа нь жил бүр өөрчлөгддөг тул заавал нягтлах хэрэгтэй.)
2.	Шалгалт өгөх хуудас хүлээж авна.	5 сар	10 сар	Шалгалт өгөх хуудас шуудангаар ирнэ.
3.	Шалгалтын өдөр	6 сар	11 сар	Шалгалт өгнө.
4.	Дүнгийн мэдэгдэл хүлээж авна.	7 сар	12 сар	Дүнгийн мэдэгдэл шуудангаар ирнэ. (Шалгалт өгөгчийн элсэх хүсэлт гаргасан сургуулийн лавлагааны дагуу JASSO-гоос шалгалт өгөгчийн дүнг сургуульд мэдэгдэнэ.)

*1 Явуулж буй хотоосоо хамааран шуудангаар болон онлайнар бүртгүүлж болно. Илүү дэлгэрэнгүйг доорхи вэбсайтаас хараарай!

i Японд суралцах шалгалт (EJU)-д хэрхэн бүртгүүлэх
https://www.jasso.go.jp/en/study_j/eju/examinee/procedure/application.html

5. Японд суралцах шалгалтын давуу талыг нягтлаарай!

1. Тэтгэлэг захиалах тогтолцоо

Японд суралцах шалгалт (EJU)-д өндөр оноо авч, Японы их дээд сургууль (факультет), богино хугацааны дээд сургууль, техникийн коллеж (3-р курсээс дээших курс), мэргэжлийн сургуулийн үндсэн оюутнаар хувийн зардлаар сурах гадаад оюутан нь Японы Оюутныг Дэмжих Байгууллагаас олгодог тэтгэлэг ("Monbukagakusho Honors Scholarship for Privately-Financed International Students")-ийг урьдчилан захиалах боломжтой.

Тэтгэлгийн хэмжээ: Сард 48,000 йен (2019 оны байдлаар)

Хүсэлт гаргах арга: Японд суралцах шалгалт (EJU) өгөхөөр өргөдөл гаргах үедээ заасан аргаар бүртгүүлэх

Сонгон шалгаруулах арга: Японд суралцах шалгалт (EJU) дээр авсан онооны дагуу шалгаруулна.

i Гадаад оюутныг хүлээн авах дэмжих хөтөлбөрийн захиалгын тогтолцоо
https://www.jasso.go.jp/en/study_j/scholarships/shoureihi/yoyakuseido/index.html

2. Шалгалт өгөх тоо болон насны хязгаар байхгүй. Дүнгийн хүчинтэй хугацаа 2 жил!

Японд суралцах шалгалт (EJU) -ыг хэдэн ч удаа өгч болно. Насны хязгаар байхгүй. Дүнгийн хүчинтэй хугацаа 2 жил (Хамгийн ихдээ сүүлийн 4 удаагийн шалгалтын дүнг хэрэглэж болно) боловч нэг сургуульд мэдүүлэх дүн нь эдгээрийн дотроос аль нэг удаагийнх нь байх ёстой. Мөн хичээл бүрээр өөр өөр хугацаанд өгсөн дүнг сургуульд гаргаж өгч болохгүй. Сургуулиуд Японд суралцах шалгалт (EJU) өгсөн хугацааг заасан байх тохиолдол их байдаг тул элсэхийг хүсч буй сургуулийнхаа оюутан элсүүлэх журамтай заавал танилцаарай.

3. Япон явахаасаа өмнө сургуульд орох зөвшөөрөл авах

Япон руу явалгүйгээр Японд суралцах шалгалтыг өөрийн улс, бүс нутагтаа өгч, сургуульд орох зөвшөөрөл авах боломжтой!

i Японд суралцах шалгалт өгөх замаар Японд очихоос өмнө элсэлтийн зөвшөөрөл олгодог сургуулийн жагсаалт (180 орчим сургууль)
https://www.jasso.go.jp/en/study_j/eju/examinee/prearrival/international.html

6. Японд суралцах шалгалтын өмнөх жилүүдэд ирсэн асуулттай танилцаж бэлдээрэй!

i Японд суралцах шалгалтын өмнөх жилүүдэд ирсэн асуултын жишээ
https://www.jasso.go.jp/en/eju/examinee/pastpaper_sample/index.html

● Японд суралцах шалгалтын асуулт (Сонсох, сонсох-униш шалгалтын асуулт, CD-тэй)



Японд суралцах шалгалтын өмнөх жилүүдэд ирсэн асуулт
 Бэлтгэн, хянан тохиолдуулсан: JASSO
 Хэвлэсэн: Bonjinsha Co., Ltd
 (Япон болон Өмнөд Солонгост худалдаалдаг)
 ※ Японд суралцах материал, гарын авлагатай танилцах цэг (Хуудас 45-ийг харах)-т танилцах боломжтой.

Хаанаас лавлах

i Гадаадад авах шалгалтын талаар
https://www.jasso.go.jp/en/study_j/eju/examinee/contact/index.html (Гадаадад авах шалгалт хэрэгжүүлэгч байгууллага)

i Японд авах шалгалтын талаар
 Японд суралцах шалгалтын алба, УТАС: 0570-55-0585, Email: eju@sdcj.co.jp, ※ Гадаадаас холбоо барих УТАС: +81-42-649-9571

i Японд суралцах шалгалт (EJU) **EJU**
https://www.jasso.go.jp/en/study_j/eju/index.html

i Японд суралцах шалгалтад тэнцсэн оюутнуудын дуу хоолой
https://www.jasso.go.jp/en/study_j/eju/examinee/voice/index.html

ЯПОНД СУРАХАД ӨГӨХ ШАЛГАЛТУУД

Элсэхийг хүсч буй сургуулийнхаа элсэлтийн шалгалтын журамтай танилцаж, заасан шалгалтыг өгөөрэй.

1. Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT)

Төрөлх хэл нь япон хэл бус хүмүүсийн япон хэлний түвшинг шалгаж тогтоодог шалгалт. 7 болон 12 сард Япон болон гадаад улсуудад зохион байгуулагддаг.

1. Японд явагдах шалгалт

Японы Олон Улсын Боловсролыг Дэмжих Нийгэмлэг (JEES)

(Япон хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийн төв, ажлын өдөр 09:30-17:30 цаг)

Утас: (+81)3-6686-2974

 **Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT Японд явагдах шалгалт)**
<http://info.jees-jlpt.jp/>

2. Японоос бусад улсад явагдах шалгалт

Бие Даасан Захиргааны Байгууллага Япон Сан
Факс: (+81)3-5367-1025

 **Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT)**
<https://www.jlpt.jp/e/index.html>

2. Элсэлтийн ерөнхий шалгалт

Япон оюутнуудын улсын их дээд сургууль болон зарим хувийн их дээд сургууль (факультет)-д элсэн ороходоо өгдөг шалгалт. Ихэнх сургуулиуд гадаад оюутнаас энэхүү шалгалтыг өгөхийг шаарддаггүй боловч зарим их дээд сургуулийн факультет (ерөнхийдөө анагаах ухаан болон шүд эмчилгээний анги)-д элсэн ороход тус шалгалтыг өгөхийг шаарддаг сургууль ч байдаг.

 **Их Дээд Сургуулийн Элсэлтийн Ерөнхий Шалгалт Зохион Байгуулах Төв**
<https://www.dnc.ac.jp/>



3. Японд сурахад өгөх бусад шалгалт

● **Англи хэлний түвшин тогтоох шалгалт**
TOEFL®, IELTS, TOEIC®, англи хэлний практик чадварыг тогтоох шалгалт (EIKEN)

● **Бүрэн дунд боловсролын мэдлэг шалгах шалгалт**
SAT, ACT, Олон улсын баклаврын шалгалт, өөрийн оронд өгсөн элсэлтийн ерөнхий шалгалтын дүн



Зөвлөгөө

Японы ихэнх их дээд сургуулиуд сургуульд элсэх өргөдөл гаргах үед англи хэлний түвшинг нотлох гэрчилгээ гаргаж өгөхийг шаарддаг. Иймээс Япон хэлний сургуульд сурч байх үедээ англи хэлний шалгалт өгөөд үзээрэй.



ОЮУТНЫ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ (2)

Гадаад оюутнууд өдөр хоногийг хэрхэн өнгөрүүлдэг юм бол? Та бүгдийн эргэлзээг тайлж, Японд сурч буй оюутнуудын амьдралыг нэг тольдон үзье. Мөрөөдлийнхөө төлөө хичээх гадаад оюутнуудын дуу хоолойг сонсоорой.



Японд сурсан мэдлэг, туршилагаа ашиглан өөрийн орныхоо хот төлөвлөлтийн асуудлыг шийдэхэд хувь нэмэр оруулахыг хүсэж байна.

Хоккайдо нь байгаль сайхантай, миний эх оронтой маань ижил байв. Шикоку бол соёл болон байгалиа сайн хамгаалж хадгалсан.

Японы олон олон хотуудыг үзсэнээр Монголынхоо хотуудын ирээдүйн дүр төрхийг бага зэрэг төсөөлж чаддаг болсон. Ирээдүйд Японд судалсан мэдлэг, туршилагаа ашиглан эх орныхоо хотын асуудлыг шийдэхэд хувь нэмэр оруулна гэж боддог.

Токио их сургууль, Хот Төлөвлөлтийн инженерингийн анги, Докторантур
Ганзориг Лувсанжамц (Монгол)

Их сургуульд сурч байхдаа архитектурын хичээлд сууж, зураг төсөл дизайны замаар явсан. Нийгэмд гарч 5 орчим жил ажилласныхаа дараа илүү том хэмжээний ажил хийж үзье гэж бодох болж, Японд сурахаар шийдсэн. Эхэндээ судлаач оюутнаар Японд ирсэн. Аспирантурын элсэлтийн шалгалт өгөх тул өдөр бүр түүнд бэлдсэн.

Жил хагас хичээсний үр дүн гарч, магистрын ангид элсэн орж чадсан. Гэхдээ магистрт орсны дараа судалгааны ажил маань илүү завгүй болсон ч олон хүмүүсийн заавар, танилцуулсны дагуу Япон орноор аялж чадсан. Токио хотоор алхах хүмүүс бүгд завгүй. Осака хун сайтай. Киотогийн түүх, сүм хийд гайхалтай.



Миний нэг өдөр

8:00 Босно. Фитнесс, өглөөний хоол, сургууль

Байр маань фитнесстэй тул 7 хоногт 3 удаа бие хаагаа хөдөлгөхийг хичээлдэг.

10:00 Судалгаа

Сургууль хүртэл 1 цаг орох тул вагон дотор эрдэм шинжилгээний ажлаа уншиж, сургуульдаа очоод судалгаагаа хийнэ.

14:00 Өдрийн хоол

Өдрийн хоолоо оюутны гуанзандаа ихэвчлэн иддэг ч хааяа сургуулийнхаа ойролцоох иж бүрдэл хоолны газраар ордог. Байнга махтай хоол захиалдаг. Хоолоо идээд судалгааны ажлаа хийнэ.

17:00 Гудамжаар алхана.

Өнөөдөр 7 хоногт 1 удаа хийдэг алхалтын өдөр. Ихэвчлэн хотын төвийн төвлөрөл ихтэй гудмаар алхаж, хотын төлөв байдлыг мөн ажиглана. Хааяа оршин суугчдаас ярилцлага авна.

19:00 Оройн хоол

Алхаж явахад минь орж үзмээр хоолны газар харгалдсан тул тэнд оройн хоолоо идсэн. Авсан зураг болон тэмдэглэлээ нэгтгэнэ.

22:00 Гэртээ харьж, амарна.

Сургуулиасаа 21 цагийн үед гараад харьж ирээд ном унших юмуу кино үзнэ. Найзуудтайгаа юу дуртайгаа ярьж зогсох үе ч бий.

0:00 Орондоо орно

Өглөө дагал хийдэг тул шөнө сайн унтдаг.



JAPAN



Менежерийнхээ зөвлөсний дагуу япон хэл үзэж, Японд сурахаар шийдсэн.

Васэда их сургууль, утга зохиол судлал, археологийн анги

Ахмед Мухмед Муханмад Абтелар (Египет)

Хүүхэд байхаасаа хөл бөмбөгийн тамирчин болохыг мөрөөддөг байсан ч намайг хамгийн дэмждэг аавыгаа насбарсны дараа өөр замаар явахаас өөр аргагүй болсон юм.

Ингээд ажилд орохын тулд мэргэжлийн сургуульд орсон. Сургуулийнхаа дадлагаар 5 одтой зочид буудалд дадлага хийсэн юм.

Ажлаа хийж байхдаа рестораны өмнө дугаарлан зогсох үйлчлүүлэгчдийг хараад их гайхав. Египетэд дугаарлана гэсэн ойлголт байхгүй учраас тэр л дээ. Яагаад энэ хүмүүс дугаарлан зогсож байгаа юм бол гэж менежерээсээ асуухад энэ хүмүүс япончууд, Японд дугаарлах заншил бий гэж хэлэв.

Миний сэтгэл хөдөлж, энэ Япончуудтай харьцмаар байгаагаа менежертээ хэлэхэд Японоор мэндчилээд үзвэл гэв. Ингээд би шууд туршаад үзэв. Тэдгээр япончууд бүгд инээмсэглэн харцу мэндчилэхэд тэр зочидтой улам харьцмаар санагдав. Тэгэхэд менежер маань чи энд ажилд орсноос залуу хүн юм чинь их сургуульд орж, япон хэл үзвэл тэдний зан заншилыг ч ойлгож мэддэг болно, Японд ч сурч чадна гэж зөвлөсний дагуу япон хэл үзэж, Японд сурахаар болсон.

Ирээдүйд Египет, Японы хооронд гүүр нь болж ажиллахыг хүсэж байна.



Миний нэг өдөр

5:00 Ном уншина.

Хүү маань боссон байвал хамт тоглоно.

10:40 Семинар

Илтгэл, хэлэлцүүлэг, бусад аспирантурын оюутнуудын курсын ажлын илтгэлийг сонсоно.

12:30 Өдрийн хоол

Ерөнхийдөө бэнто иддэг. Уйдахаараа сургуулийнхаа гуанз болон ойролцоох ресторанаар үйлчлүүлдэг.

14:00 Судалгааны хүрээлэн

Судалгааныхаа ажлыг хийнэ. Малтлагын судалгааны анализ болон симпозиумын бэлтгэл ажилд туслах, сайн дурын ажил гэх мэт

20:00 Харьж ирнэ

Орой 7 хоногт 2 удаа хөл бөмбөг тоглоно.

Амралтын өдөр Цагийн ажил, сайн дурын ажил, аялал

Цагийн ажил болон өөр соёл заах багш хийж, гэр бүлээрээ аялдаг.


УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРЭХ БҮРДҮҮЛЭЛТ

ХЗЯ, Гадаадын Иргэн, Харьяатын Газар <http://www.immi-moj.go.jp/english/index.html>

Виз болон оршин суух статус

Японы хилээр нэвтрэхийн тулд урьдчилан виз авах шаардлагатай. Виз нь дотроо хэд хэдэн төрөлтэй байдаг бөгөөд тухайн хүний хил нэвтрэх зорилго болон зэрэг дэвээс шалтгаалж, оршин суух статус нь шийдэгддэг.

Японы их дээд ургууль болон богино хугацааны дээд сургууль, техникийн коллеж, мэргэжлийн сургууль, япон хэлний сургалтын байгууллагад суралцахад "Сурах" гэсэн статус хэрэгтэй. Сурах хугацаа нь 4 жил 3 сар, 4 жил, 3 жил 3 сар, 3 жил, 2 жил 3 сар, 2 жил, 1 жил 3 сар, 1 жил, 6 сар, эсхүл 3 сар байдаг.



1. Японд оршин суух зөвшөөрөл (COE) авахаар хүсэлт гаргах

“Японд оршин суух зөвшөөрөл” (COE) авахаар Японд суралцахыг хүсэгч (хүсэлт гаргагч), эсвэл түүний төлөөний хүн (хүсэлт гаргагчийн гэр бүл хамаатан, эсвэл хүлээж авах сургуулийн ажилтан г.м.) Япон улс дахь орон нутгийн Гадаадын Иргэн, Харьяатын Газарт хандана.

- * Ихэнх тохиолдолд хүлээж авах боловсролын байгууллага нь төлөөлөн хүсэлт мэдүүлдэг.
- * Шаардлагатай бичиг баримтын талаар элсэх сургуулиасаа тодруулаарай.

2. Японд амьдрахад гарах хэрэгцээт зардлыг төлөх төлбөрийн чадвартайг нотлох баримт

“Оршин суух зөвшөөрөл” авах болон виз мэдүүлэх үед Японд суралцах үед гарах зардлыг төлөх бэлтгэл хангагдсан эсэхийг нотлох баримт гаргаж өгөхийг шаардах тохиолдол байдаг.

- **Шаардагдах бичиг баримт** ... Зардал даах хүн /Японд сурахыг хүсэгч, эсхүл асран хамгаалагч/-ий хадгаламжийн дансны үлдэгдлийн хуулга
Сүүлийн хэдэн жилийн орлогын болон татвар төлсөн баримт гэх мэт

3. Виз мэдүүлэх

“Оршин суух зөвшөөрөл” (COE) гарсны дараа өөрийн оронд байрлах Япон Улсын Дипломат Төлөөлөгчийн Газарт виз мэдүүлнэ.

● Шаардагдах бичиг баримт

1. Гадаад паспорт
2. Виз мэдүүлгийн хуудас
3. Цээж зураг
4. Оршин суух зөвшөөрөл (COE)
5. Бусад бичиг баримтыг гаргаж өгөхийг шаардах тохиолдол ч байдаг

4. Японы улсын хилээр нэвтрэх

Япон улсын хилээр нэвтрэхэд дараах бичиг баримт шаардлагатай.

● Шаардагдах бичиг баримт

1. Гадаад паспорт
2. Гадаад улс дахь Япон Улсын Дипломат Төлөөлөгчийн Газраас олгосон виз
3. Оршин суух зөвшөөрөл (авсан тохиолдолд)

5. Оршин суух үнэмлэх

3 сараас дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэнд оршин суух үнэмлэх олгоно. Энэ үнэмлэхийг биедээ байнга авч явах хэрэгтэй.


Оршин суух үнэмлэх олгох

Шинчитосэ, Нарита, Ханэда, Чюүбү, Кансай, Хирошима, Фүкүока нисэх онгоцны буудлын боомтоор хил нэвтрэх тохиолдолд:

Хил нэвтрүүлэх шалгалтын үед паспортон дээр “Хилээр нэвтрэхийг зөвшөөрөв” гэсэн тамгатай наалт нааж, оршин суух үнэмлэх олгодог. Японд оршин суух газраа шийдээд, 14 хоногийн дотор оршин суух үнэмлэхээ авч, оршин суугаа газрынхаа захиргаанд бүртгүүлэхээр хандана.

Дээрхээс бусад боомтоор хил нэвтрэх тохиолдолд:

Хил нэвтрүүлэх шалгалтын үед гадаад паспортон дээр “Хилээр нэвтрэхийг зөвшөөрөв” гэсэн тамгатай наалт нааж, “Оршин суух үнэмлэх дараа олгох” гэсэн тамга дардаг. Японд оршин суух газраа шийдээд 14 хоногийн дотор “Оршин суух үнэмлэх дараа олгох” гэсэн тамга дарагдсан паспортго авч очин оршин суугаа газрынхаа захиргаанд бүртгүүлэхээр хандана. “Оршин суух үнэмлэх”-ийг оршин суугаа газрын захиргаанаас дараа хаягаар илгээдэг.



Оршин суух үнэмлэх

6. Хувийн дугаар (Social Security and Tax Number)

Оршин суух хот, дүүрэг, тосгоны захиргаанд очиж оршин суугчаар бүртгүүлэхэд хувийн дугаар бүхий карт олгодог. Хувийн дугаар нь нэг хүнд нэг л байх бөгөөд захиргааны байгууллагад очиж бүрдүүлэлт хийхэд хэрэгтэй болдог. Энэ нь 12 оронтой дугаар бөгөөд оршин суух үнэмлэх дээр байх 12 оронтой тооноос өөр юм.

Хувийн дугаарыг дараах тохиолдолд шаардаж болох тул энэхүү дугаар бичигдсэн “Мэдэгдэх карт” болон “Хувийн карт”-ыг сайтар хадгалаарай.

- Захиргааны байгууллага дээр очиж бүрдүүлэлт хийх үед
- Цагийн ажил хийх үед
- Банкин дээр гадаадаас мөнгө хүлээн авах үед



Мэдэгдэх карт

7. Шалгалт өгөхөөр Япон явах үеийн бүрдүүлэлт

Шалгалт өгөхөөр Япон явах бол шалгалт өгөх сургуулийнхаа шалгалтад орох эрхийн хуудсыг Гадаад улс дахь Япон Улсын Дипломат Төлөөлөгчийн Газарт авч очин, “Богино хугацааны виз авах шаардлагатай. Японд байх хугацаа нь 15, 30, 90 хоног байна. Гэхдээ визгүй зорчих улсын иргэн бол виз мэдүүлэх шаардлагагүй.

* Визгүй зорчих улсын иргэн шалгалтанд тэнцсэн бол улс руугаа буцаж, "Оюутны виз" авах шаардлагатай.

9. Түр нутаг буцах үеийн бүрдүүлэлт

Гадаад оюутан түр нутаг буцах буюу өөр улс руу явахаар бол Японоос гарахаасаа өмнө тухайн орон нутгийн Гадаадын Иргэн, Харьяатын Газарт очиж хилээр дахин нэвтрэх зөвшөөрөл авах шаардлагатай.

Гэхдээ хүчинтэй гадаад паспорт, оршин суух үнэмлэхтэй оршин суугч нь Японы хилээр гарах үедээ дахин орж ирнэ гэдгээ хэлж, хилээр гарснаасаа хойш 1 жилийн дотор (1 жилийн дотор оршин суух хугацаа нь дуусах хүний хувьд тухайн дуусах өдөр хүртэл) Япон улсад дахин орж ирэх тохиолдолд Японы хилээр гарахаасаа өмнө дахин орж ирэх зөвшөөрөл авах шаардлагагүй.

8. Оршин суух статусаас гадуур ажил эрхлэх зөвшөөрөл

“Сурах” статус нь Японы сургуульд суралцахад олгогдох бөгөөд энэхүү статустай хүнд ажил хийхийг зөвшөөрдөггүй. Гэхдээ тухайн орон нутгийн Гадаадын Иргэн, Харьяатын Газарт очиж “Оршин суух статусаас гадуур ажил эрхлэх зөвшөөрөл” авч, цагийн ажил хийж болно (Хуудас 38-ыг хар).

* Сурах статус бүхий хүн 3 сараас дээш хугацаагаар байхаар анх удаа хил нэвтэрч буй тохиолдолд нисэх онгоцны буудал дээр “Оршин суух статусаас гадуур ажил эрхлэх зөвшөөрөл” авахаар мэдүүлж болно.

* Японд ирснийхээ дараа "Оршин суух статусаас гадуур ажил эрхлэх зөвшөөрөл" авахаар мэдүүлэх бол тухайн орон нутгийн Гадаадын Иргэн, Харьяатын Газарт мэдүүлнэ.

10. Оршин суух хугацаа сунгуулах

Япон улсын хилээр нэвтрэх үед тогтоогдсон оршин суух хугацаа дуусах өдрөөс цааш үргэлжлүүлэн оршин суухаар бол тухайн орон нутгийн Гадаадын Иргэн, Харьяатын Газарт оршин суух хугацаагаа сунгуулах зөвшөөрөл авахаар хандана (Ерөнхийдөө оршин суух хугацаа дуусахаас 3 сарын өмнөөс хүсэлтийг хүлээж авдаг).

Оршин суух хугацаа хэтрүүлэн хууль бусаар оршин суувал шийтгэл хүлээлгэх болон албадан гаргах арга хэмжээ авдаг.



Оршин суух хугацаагаа сунгуулахаа мартаад хууль бусаар оршин суусан тохиолдолд сургуулиасаа хасагдах, тэтгэлэг авч чадахгүй байх тохиолдол гардаг.

外国人用 (再入国)	再入国入国記録 DISEMBARKATION CARD FOR REENTRANT ② [ARRIVAL]	再入国出国記録 EMBARKATION CARD FOR REENTRANT ① [DEPARTURE]
667709	<p>氏名 Family Name Name Given Names</p> <p>生年月日 Day Month Year 年 航空機便名・船名 Last Flight No./Vessel</p> <p>以下の質問について、該当するものに☑を記入し、署名して下さい。(特別永住者の方は署名のみ)。Please check the applicable items and put your signature. (For special permanent resident, please put your signature only.)</p> <p>1 あなたは、日本国又は日本国以外の国において、刑事事件で有罪判決を受けたことがありますか？ Have you ever been found guilty in a criminal case in Japan or another country? <input type="checkbox"/> はい Yes <input type="checkbox"/> いいえ No</p> <p>2 あなたは、現在、麻薬、大麻、あへん若しくは覚せい剤等の規制薬物又は銃器、刀剣類若しくは火薬類を所持していますか？ Do you presently have in your possession narcotics, marijuana, opium, stimulants, or other controlled substance, swords, explosives or other such items? <input type="checkbox"/> はい Yes <input type="checkbox"/> いいえ No</p> <p>以上の記載内容は事実と相違ありません。 I hereby declare that the statement given above is true and accurate.</p> <p>署名 Signature</p>	<p>氏名 Family Name Name Given Names</p> <p>生年月日 Day Month Year 年 主な渡航先国名 Destination</p> <p>航空機便名・船名 Flight No./Vessel 出国予定期間 Intended period out of Japan <input type="checkbox"/> 1年以内 Within one year <input type="checkbox"/> 1年超2年以内 but within two years <input type="checkbox"/> 2年超 Over two years</p> <p>次のいずれかに☑を記入してください。 Please check either one of the boxes below.</p> <p><input type="checkbox"/> 1. 一時的な出国であり、再入国する予定です。 I am leaving Japan temporarily and will return.</p> <p><input type="checkbox"/> 2. 「再入国許可」の有効期間内に再入国の予定はありません。 I do not plan to re-enter Japan while my re-entry permit is valid.</p> <p>(地方入国管理官署で「再入国許可」を受けており、その有効期間内に再入国予定のない方は、☑して下さい。) (Check the box if you do not plan to re-enter Japan while your re-entry permit, which you have obtained at a regional immigration bureau, is valid.)</p> <p>署名 Signature</p>

Дахин улсын хилээр нэвтрэх үед бөглөх ED карт



Япон улсын хилээр гарахдаа оршин суух үнэмлэхээ заавал үзүүлэхийн зэрэгцээ Япон улсын хилээр гарах, дахин нэвтрэх ED хуудасны дахин орж ирэх гэсэн хэсэгт тэмдэглэгээ хийгээрэй.

11. Оршин суух статусаа өөрчлөх

Одоогийн эрхэлж буй үйл ажиллагаа болох "сурах"-аа болиод өөр оршин суух статуст хамаарах үйл ажиллагаа (ажилд орох гэх мэт) явуулах бол тухайн орон нутгийн Гадаадын Иргэн, Харьяатын Газарт хандаж, оршин суух статусын өөрчлөлт хийлгэх шаардлагатай.



Зөвшөөрөл авалгүйгээр орлого олох болон цалин хөлс авах үйл ажиллагаа явуулбал шийтгэл хүлээлгэх болон албадан гаргах арга хэмжээ авдаг.

12. Оршин суух статусыг хүчингүй болгох

Хүсэлт гаргагч нь явуулах гэж буй үйл ажиллагаа болон түүхээ хуурамчаар мэдүүлэх, хуурамч бичиг баримт гаргаж өгсөн тохиолдолд оршин суух статусыг нь хүчингүй болгодог.



“Сурах” статустай хэрнээ сургуульдаа явалгүй ажил хийх тохиолдолд, мөн хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд оршин суух статусыг нь хүчингүй болгодог.

13. Гэр бүлээ авчрах

Та “Сурах” статус бүхий оршин суух зөвшөөрлөөр их дээд сургууль гэх мэт боловсролын байгууллагад суралцаж буй тохиолдолд таны гэр бүлийн хүн болон хүүхэд тухайн хугацаанд “Гэр бүлийн оршин суух” статусаар Япон улсад оршин суух боломжтой.

Гадаад оюутан өөрөө Японы амьдралд дасаж, эдийн засаг болон бусад талын бэлтгэлээ хангасны дараа гэр бүлээ дуудаж ирүүлэхийг зөвлөх байна.



Таны гэр бүлийн хүмүүс “Богино хугацааны виз (Temporary visitor)” (“жуулчлалын виз” гэгддэг) -ээр Япон улсад орж ирсэн бол Япон улсад “Гэр бүлтэйгээ оршин суух (Dependent)” статус болгон өөрчлөх нь төвөгтэй тул энэ тал дээр сайтар анхаараарай.

14. Гадаадын Иргэн Харьяатын Газар, харьяа хот дүүрэг, тосгоны захиргаанд бүртгүүлэх

Доорхи тохиолдолд нэн даруй мэдэгдэх, эсхүл хүсэлт гаргана.

- **Орон нутгийн Гадаадын Иргэн, Харьяатын Газарт**
Овог нэр, хүйс, төрсөн огноо, иргэний харьяалал, сургууль өөрчлөгдсөн болон оршин суух картаа гээсэн, бохирдуулж гэмтээсэн тохиолдолд
- **Хот, дүүрэг, хороо, тосгоны захиргаанд**
Оршин суух хаяг өөрчлөгдсөн, мөн сурч дуусаад нутаг буцах болсон тохиолдолд

ЯПОНД СУРАХАД ГАРАХ ЗАРДАЛ

Сурах нийт зардлыг бодитойгоор тооцож, өөрт буй мөнгийг оролцуулан төсөв мөнгөний төлөвлөгөөгөө сайтар гаргах нь Японд очсоны дараа тайван амьдрах боломж олгоно. Төлөвлөгөөгөө үнэн зөв гаргаж уу гэдгийг магадлахын тулд Японд сурахад шаардагдах зардал мөнгийг тооцоолж үзье.



		Багцаа тооцоо (Улсын 4 жилийн их дээд сургууль)		Өөрт хэрэгтэй зардлыг тооцож үзээрэй.
Өргөдөл өгөхөөс өмнө гарах зардал	Төрөл бүрийн шалгалтын төлбөр EJU, JLPT, TOEFL® г.м.	28,080 йен	Японд EJU (2 хичээлээс дээш)-г 2 удаа өгөх тохиолдолд	йен
	Элсэхийг хүсч буй сургуулийн элсэлтийн шалгалтын хураамж	17,000 йен	Улсын их сургуульд 1 удаа шалгалт өгөхөд	йен
	Эрүүл мэндийн үзлэгийн төлбөр (Сургуулиасаа хамаарна.)	6,000 йен	Улсаасаа хамаараад өөр	йен
	Элсэлтийн материалын шуудангийн зардал (Сургуулиасаа хамаарна)	2,000 йен	Улсаасаа хамаараад өөр	йен
Элсэлтийн шалгалт өгөхөд гарах зардал	Онгоцны тийз, Японд байрлах зардал	100,000 йен	Улсаасаа болон Японд байх хугацаанаасаа хамаараад өөр	йен
	Паспорт хэвлүүлэх зардал	12,000 йен	Улсаасаа хамаараад өөр	йен
	Визний хураамж	3,000 йен	Улсаасаа хамаараад өөр	йен
Сургуульд орох шийдвэр гарсны дараа гарах зардал	Япон явахад гарах зардал	70,000 йен	Улсаасаа хамаараад өөр	йен
	Японд байрлах зардал (Орон байр шийдэгдэх хүртэл зочид буудлын төлбөр)	30,000 йен	Японд байх хугацаанаасаа хамаараад өөр	йен
	Элсэлтийн хураамж	282,000 йен	Улсын их сургууль	йен
	Эхний жилийн сургалтын төлбөр	535,800 йен	Улсын их сургууль	йен
	Унааны зардал	60,000 йен	2017 оны хувийн зардлаар сурах гадаад оюутны амьжиргааны байдлын судалгаанаас 12 сарын дүнгээр тооцов.	йен
	Хоол хүнс	324,000 йен		йен
	Түрээсийн төлбөр	408,000 йен		йен
	Цахилгаан, дулаан, усны төлбөр	84,000 йен		йен
	Даатгал, эмчилгээний зардал	36,000 йен		йен
	Хобби, зугаа цэнгээн	72,000 йен		йен
Бусад	84,000 йен	йен		
Нийт	2,153,880 йен			йен

АМЬЖИРГААНЫ ӨРТӨГ, ЮМНЫ ҮНЭ

1. Юмны үнэ магадлаж хараарай.

Гол нэр төрлийн барааны үнэ

Цагаан будаа (5 кг)	2,137 йен (19US\$)
Талх (1 кг)	435 йен (4US\$)
Сүү (1,000мл)	223 йен (2US\$)
Өндөг (10ш)	248 йен (2US\$)
Алим (1 кг)	497 йен (4US\$)
Байцаа (1 кг)	244 йен (2US\$)




Хийжүүлсэн ундаа (500мл)	97 йен (1US\$)
Гамбургер	174 йен (2US\$)
Бензин (1л)	132 йен (1US\$)
00-ын цаас (12ш)	279 йен (2US\$)
Киноны тасалбар	1,800 йен (16US\$)
Такси (4км)	1,450 йен (13US\$)

Эх сурвалж: "Засгийн газрын статистикийн нэгдсэн лавлах" 1 америк долларыг 114 йенээр тооцоолов.


2. Амьжиргааны өртгөө тооцоолоорой!

Гадаад оюутны нэг сарын амьжиргааны өртөг (Сургалтын төлбөр ороогүй) дараах байдалтай байна. Том хотуудын амьжиргааны өртөг хөдөө, орон нутагтай харьцуулахад өндөр байдаг.



1 сарын зардал (Сургалтын төлбөр багтаагүй)

(Улсын дундаж)



Түрээсийн зардал (Бүс нутгаар)

※ 1US\$ = 114 йен

	Йен	Америк доллар
Улсын дундаж	34,000	298
Хоккайдо	31,000	272
Тоохоку	25,000	219
Канто	39,000	342
Токио	43,000	377
Чюүбү	26,000	228
Кинки	35,000	307
Чюүкоку	24,000	211
Шикоку	23,000	202
Кюшю	24,000	211

Эх сурвалж: "Хувийн зардлаар сурч буй гадаад оюутны аж байдлын судалгаа", 2017 (JASSO)

СУРГАЛТЫН ТӨЛБӨР

Японы их дээд сургуулийн сургалтын төлбөр Америк, Английн их дээд сургуулиудтай харьцуулахад өндөр биш. Японы факультетын нэг жилийн элсэлтийн хураамж болон сургалтын төлбөр нь **улсын их дээд сургуулийн хувьд нийтдээ 820,000 йен (7,200US\$) орчим, муж хотын их дээд сургуулийн хувьд 930,000 йен (8,200US\$) орчим, хувийн их дээд сургуулийн хувьд 1,100,000 йен (9,700US\$)-1,640,000 йен (14,400US\$) орчим байдаг (Анагаах ухаан, эрүү нүүр шүд, эм зүйн анги ороогүй).**

Мөн **тэтгэлэг олгох болон сургалтын төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх тогтолцоо бусад улстай харьцуулахад сайтар хөгжсөн байдаг.** Эхний жилийн сургалтын төлбөрт элсэлтийн хураамж, сургалтын төлбөр, сургалтын орчин, материаллаг бааз ашиглалтын төлбөр багтдаг. Элсэлтийн хураамжийг зөвхөн эхний жил төлнө.

* Улсын их дээд сургуулийн хувьд өөр тохиолдол бий.

Эхний жилийн сургалтын төлбөрийн дундаж (Нэг ам. долларыг 114 йенээр тооцов)

● Аспирантур

Аспирантур	Элсэлтийн хураамж (Зөвхөн эхний жил)	Сургалтын төлбөр	Эхний жилийн нийт дүн		Төгсөх хүртэлх нийт дүн ^{*1}		
	Йен	Йен	Йен	US\$	Йен	US\$	
Улсын (Магистр)	282,000	535,800	817,800	7,174	1,353,600	11,874	
Муж, хотын (Магистр)	364,727	537,878	902,605	7,918	1,440,483	12,636	
Хувийн (Магистрын анги)	Урлаг	222,861	1,218,547	1,441,408	12,644	2,659,955	23,333
	Инженеринг	208,111	951,607	1,159,718	10,173	2,111,325	18,520
	Эрүүлийг хамгаалах	246,845	853,128	1,099,973	9,649	1,953,101	17,132
	Байгалийн ухаан	199,244	886,464	1,085,708	9,524	1,972,172	17,300
	ХАА, мал эмнэлэг	218,358	802,136	1,020,494	8,952	1,822,630	15,988
	Эм зүй	185,250	834,025	1,019,275	8,941	1,853,300	16,257
	Гэр ахуй, дизайн	239,091	718,855	957,946	8,403	1,676,801	14,709
	Боловсрол	202,894	735,827	938,721	8,234	1,674,548	14,689
	Нийгмийн ухаан	211,083	686,458	897,541	7,873	1,583,999	13,895
	Анагаах ухаан	189,725	699,422	889,147	7,800	1,588,569	13,935
Хүмүүнлэгийн ухаан	203,895	645,808	849,703	7,454	1,495,511	13,119	
Улсын (Доктор)	282,000	535,800	817,800	7,174	1,889,400	16,574	
Муж, хотын (Доктор)	364,727	537,878	902,605	7,918	1,978,361	17,354	
Хувийн (Докторын анги)	Урлаг	233,986	1,100,426	1,334,412	11,705	3,535,264	31,011
	Эрүүлийг хамгаалах	258,951	799,934	1,058,885	9,288	2,658,753	23,322
	Байгалийн ухаан	204,346	792,232	996,578	8,742	2,581,042	22,641
	ХАА, мал эмнэлэг	218,483	802,160	1,020,643	8,953	2,624,963	23,026
	Инженеринг	189,363	797,539	986,902	8,657	2,581,980	22,649
	Гэр ахуй, дизайн	236,928	718,085	955,013	8,377	2,391,183	20,975
	Эм зүй	179,545	716,022	895,567	7,856	2,327,611	20,418
	Боловсрол	225,912	690,116	916,028	8,035	2,296,260	20,143
	Шүд эрүү нүүр	232,075	642,666	874,741	7,673	2,160,073	18,948
	Нийгмийн ухаан	202,430	612,401	814,831	7,148	2,039,633	17,892
Хүмүүнлэгийн ухаан	206,800	583,535	790,335	6,933	1,957,405	17,170	
Анагаах ухаан	174,718	533,549	708,267	6,213	1,775,365	15,573	

*1 Магистрын ангийн хувьд элсэлтийн хураамж болон 2 жилийн хичээлийн төлбөр, докторын ангийн хувьд элсэлтийн хураамж болон 3 жилийн хичээлийн төлбөрөөр тооцов.

● Их дээд сургуулийн факультет

Их дээд сургуулийн факультет	Элсэлтийн хураамж (Зөвхөн эхний жил)	Сургалтын төлбөр	Эхний жилийн нийт дүн		Төгсөх хүртэлх нийт дүн ^{*2}		
	Йен	Йен	Йен	US\$	Йен	US\$	
Улсын	282,000	535,800	817,800	7,174	2,425,200	21,274	
Муж, хотын	393,618	538,633	932,251	8,178	2,548,150	22,352	
Хувийн	Анагаах ухаан	1,325,507	3,717,720	5,043,227	44,239	23,631,827	207,297
	Шүд, эрүү нүүр	563,403	3,725,836	4,289,239	37,625	22,918,419	201,039
	Эм зүй	341,541	1,741,001	2,082,542	18,268	10,787,547	94,628
	Урлаг	259,312	1,376,891	1,636,203	14,353	5,766,876	50,587
	Эрүүлийг хамгаалах	272,467	1,228,341	1,500,808	13,165	5,185,831	45,490
	Байгалийн ухаан, инженеринг	242,670	1,231,676	1,474,346	12,933	5,169,374	45,345
	ХАА, мал эмнэлэг	246,282	1,166,879	1,413,161	12,396	4,913,798	43,103
	Биеийн тамир	258,265	1,035,887	1,294,152	11,352	4,401,813	38,612
	Гэр ахуй, дизайн	255,704	997,399	1,253,103	10,992	4,245,300	37,239
	Нийгмийн ухаан, боловсрол	233,136	952,976	1,186,112	10,404	4,045,040	35,483
	Нийгмийн хамгаалал	214,439	930,751	1,145,190	10,046	3,937,443	34,539
	Хууль, худалдаа, эдийн засаг	232,284	920,231	1,152,515	10,110	3,913,208	34,326
	Шинто, буддын шашин судлал	214,288	888,940	1,103,228	9,677	3,770,048	33,071

*2 Хувийн их дээд сургуулийн анагаах ухаан, эрүү нүүр шүд, эм зүйн ангийн хувьд элсэлтийн хураамж, 6 жилийн хичээлийн төлбөрөөр тооцов. Бусад ангийн хувьд элсэлтийн хураамж болон 4 жилийн хичээлийн төлбөрөөр тооцов.

● Богино хугацааны дээд сургууль

Богино хугацааны дээд сургууль		Элсэлтийн хураамж (Зөвхөн эхний жил)		Сургалтын төлбөр		Эхний жилийн нийт дүн		Төгсөх хүртэлх нийт дүн ³	
		Йен	US\$	Йен	US\$	Йен	US\$	Йен	US\$
Хувийн	Урлаг	251,226	1,181,574	1,432,800	12,568	2,614,374	22,933		
	Инженеринг	209,388	1,051,438	1,260,826	11,060	2,312,264	20,283		
	Байгалийн ухаан, ХАА	194,615	910,962	1,105,577	9,698	2,016,539	17,689		
	Хүмүүнлэгийн ухаан	242,942	868,122	1,111,064	9,746	1,979,186	17,361		
	Боловсрол, хүүхэд асрах	250,742	852,536	1,103,278	9,678	1,955,814	17,156		
	Гэр ахуй, загвар	245,642	861,628	1,107,270	9,713	1,968,898	17,271		
	Хууль, худалдаа, эдийн засаг, нийгэм	233,823	845,376	1,079,199	9,467	1,924,575	16,882		
	Биеийн тамир	238,571	816,286	1,054,857	9,253	1,871,143	16,414		

*3 Элсэлтийн хураамж болон 2 жилийн сургалтын төлбөрөөр тооцов

● Техникийн коллеж

Техникийн коллеж	Элсэлтийн хураамж (Зөвхөн эхний жил)		Сургалтын төлбөр		Эхний жилийн нийт дүн		Төгсөх хүртэлх нийт дүн ⁴	
	Йен	US\$	Йен	US\$	Йен	US\$	Йен	US\$
Улсын	84,600	234,600	319,200	2,800	788,400	6,916		

*4 Элсэлтийн хураамж болон 3 жилийн сургалтын төлбөрөөр тооцов

● Мэргэжлийн сургууль

Мэргэжлийн сургууль		Элсэлтийн хураамж (Зөвхөн эхний жил)		Сургалтын төлбөр		Эхний жилийн нийт дүн		Төгсөх хүртэлх нийт дүн ⁵	
		Йен	US\$	Йен	US\$	Йен	US\$	Йен	US\$
Хувийн	Эрүүл ахуй	165,500	1,345,750	1,511,250	13,257	2,857,000	25,061		
	Эмчилгээ	249,000	1,166,714	1,415,714	12,419	2,582,428	22,653		
	Аж үйлдвэр	213,333	1,096,500	1,309,833	11,490	2,406,333	21,108		
	ХАА	180,000	1,107,000	1,287,000	11,289	2,394,000	21,000		
	Боловсрол, нийгмийн хамгаалал	145,750	933,500	1,079,250	9,467	2,012,750	17,656		
	Худалдаа	133,750	982,250	1,116,000	9,789	2,098,250	18,406		
	Соёл боловсрол	153,000	1,019,000	1,172,000	10,281	2,191,000	19,219		
	Хувцас загвар, гэр ахуй	183,000	902,000	1,085,000	9,518	1,987,000	17,430		

*5 Элсэлтийн хураамж болон 2 жилийн сургалтын төлбөрөөр тооцов

● Япон хэлний сургалтын байгууллага

Хувийн их дээд сургууль, богино хугацааны дээд сургуулийн гадаад оюутанд зориулсан тусгай сургалт		Сургалтын төлбөр	
		Йен	US\$
1 жилийн курс		400,000-755,000	3,509-6,623
1 жил хагасын курс		642,000-1,100,000	5,632-9,649
2 жилийн курс		1,070,000-1,420,000	9,386-12,456

Эх сурвалж: Японы Оюутныг Дэмжих Байгууллага

Япон хэлний сургууль		Сургалтын төлбөр	
		Йен	US\$
1 жилийн курс		600,000-997,400	5,263-8,749
1 жил хагасын курс		772,000-1,530,000	6,772-13,421
2 жилийн курс		1,006,000-2,000,000	8,825-17,544

Эх сурвалж: Япон хэлний Боловсролыг Дэмжих Нийгэмлэг

※ Америк, Англи улсын сургалтын болон бусад төлбөр

		1 жилийн		Төгсөх хүртэлх нийт дүн ⁶	
		Йен	US\$	Йен	US\$
Америк	Муж, хотын 4 жилийн их сургууль	2,920,680	25,620	11,682,720	102,480
	Хувийн 4 жилийн их сургууль	3,960,360	34,740	15,841,440	138,960

*6 4 жилийн сургалтын төлбөр болон их дээд сургуулийн бусад төрөл бүрийн зардлаар тооцон гаргав.

Эх сурвалж: Америкт сурах гарын авлага, 2019 он

		1 жилийн		Төгсөх хүртэлх нийт дүн ⁷	
		Йен	US\$	Йен	US\$
Англи	Нийгмийн ухаан	1,500,000-2,400,000	10,000-16,000	4,500,000-7,200,000	30,000-48,000
	Байгалийн ухаан	1,800,000-3,750,000	12,000-25,000	5,400,000-11,250,000	36,000-75,000
	Анагаах ухаан	3,300,000-6,000,000	22,000-40,000	9,900,000-18,000,000	66,000-120,000

*7 3 дахь жилийн сургалтын төлбөр болон бусад зардлаар тооцов.

Эх сурвалж: "Англи улсад сурах гарын авлага", 2018 (Английн консул)

1 паундыг 150 йенээр тооцов

ТЭТГЭЛЭГ

Японд суралцахад шаардлагатай бүх зардлыг даадаг тэтгэлэг цөөхөн байдаг. Ихэнх нь амьжиргааны зардал болон сургалтын төлбөрийн зарим хэсгийг даадаг. Тиймээс Японд сурахад гарах нийт зардлыг бодитойгоор тооцож, тэтгэлэгт найдалгүйгээр өөрийн төсөв мөнгөө сайтар тооцоолоорой.

Эдийн засгийн дэмжлэг байдаг эсэх талаар судлаарай!

1. Тэтгэлэг
2. Сургалтын төлбөрөөс чөлөөлж хөнгөлөх тогтолцоо (30%, 50%, 100%-ийн хөнгөлөлт)

Хэрхэн хүсэлт гаргах талаар судлаарай!

1. **Япон явахаасаа өмнө бүртгүүлэх:** Япон явахаасаа өмнө гадаадад бүртгүүлнэ (Цөөхөн байдаг).
2. **Японд ирснийхээ дараа бүртгүүлэх:** Японд ирж сургуульдаа орсны дараа бүртгүүлнэ (Олон байдаг).

Хэн хамрагдах талаар болон тэтгэлэг олгогч байгууллагын тоог судлаарай!

Хамрагдах оюутан	Япон явахаасаа өмнө бүртгүүлэх		Японд ирснийхээ дараа бүртгүүлэх
	Японы Засгийн Газар	Орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшил	Орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшил
1 Техникийн коллежийн оюутан	○	1	21
2 ТМС-ийн мэргэшлийн ангийн оюутан	○	2	17
3 Их дээд, богино хугацааны дээд сургуулийн япон хэлний тусгай курсэд суух гадаад оюутан	○	1	5
4 3-аас бусад япон хэлний боловсролын байгууллагад сурч буй суралцагч		3	8
5 Богино хугацааны дээд сургуулийн оюутан		3	35
6 Их дээд сургуулийн факультетын сонсогч		0	3
7 Их дээд сургуулийн факультетын оюутан	○, япон хэл, соёлоор мэргэшил	9	88
8 Аспирантурын судлаач оюутан	○, багшийн мэргэжил	3	23
9 Магистрын ангийн оюутан	○, YLP	16	114
10 Докторын ангийн оюутан	○	14	114
11 Нарийн мэргэшлийн зэрэг олгох курст сурах оюутан	○	1	3

Эх сурвалж: Японы Оюутныг Дэмжих Байгууллагаас гаргадаг "Японд суралцах тэтгэлгийн гарын авлага", 2018-2019



Факультет болон аспирантурын үндсэн ангийнханд зориулсан тэтгэлэг олон байдаг.

Бүртгүүлэх шаардлагын талаар судлаарай!

- 1) Нас, 2) Иргэншил, 3) Японд сурч буй сургууль, 4) Мэргэшлийн чиглэл зэргийг заасан байдаг.



Гадаад оюутнуудад зориулсан тэтгэлэгт бүртгүүлэх үед оршин суух статус нь "Сурах" гэсэн нөхцөлтэй байхыг ихэвчлэн шаардсан байдаг.

Шалгаруулалтын талаар тодруулаарай!

Бичиг баримтын шалгаруулалт гол байр эзэлдэг. Ярилцлага болон ерөнхий мэдлэг, мэргэшлийн салбарын мэдлэг, хэлний чадвар гэх мэт бичгийн шалгалт авах тохиолдол ч байдаг

Хэрхэн бүртгүүлэх талаар магадлаарай!

Ихэнх тохиолдолд сурч буй сургуулиараа дамжуулан бүртгүүлдэг (Илүү дэлгэрэнгүйг сургуулийнхаа гадаад оюутны албанаас тодруулаарай.).



Япон явахаасаа өмнө хүсэлт гаргаж болох тэтгэлэг

Төрөл	Хэн хамрагдах, олгох байгууллагын тоо	Сарын тэтгэлэг	Ам. доллароор	Хаанаас лавлах
Япон улсын Засгийн Газар (Японы Боловсрол, Шинжлэх Ухааны Яам)-ын тэтгэлэг*1	Залуу удирдагч хөтөлбөр (Young Leaders' Program)-ийн оюутан	242,000 йен	2,123US\$	Өөрийн улсад байрлах Япон улсын дипломат төлөөлөгчийн газар болон одоо сурч буй сургууль*2
	Судлаач оюутан (Үндсэн бус оюутан)	143,000 йен	1,254US\$	
	Судлаач оюутан (Магистрантур)	144,000 йен	1,263US\$	
	Судлаач оюутан (Докторантур)	145,000 йен	1,272US\$	
	Багшийн мэргэжил дээшлүүлэх курсын оюутан	143,000 йен	1,254US\$	
	Их дээд сургуулийн факультет, техникийн коллеж, техник мэргэжлийн сургуулийн оюутан, япон хэл, соёл судлаач оюутан	117,000 йен	1,026US\$	
Reservation Program for Monbukagakusho Honors Scholarship for Privately Financed International Students (Гадаад оюутан элсүүлэхийг дэмжих хөтөлбөрийн тэтгэлэг захиалах тогтолцоо)	Японд суралцах шалгалт (EJU)-д өндөр оноо авч, Японы их дээд сургууль, богино хугацааны дээд сургууль, техникийн коллеж (3-р курсээс эхлэн), мэргэжлийн сургуулийн мэргэжлийн ангид үндсэн оюутнаар хувийн зардлаар сурах гадаад оюутан	48,000 йен	421US\$	Японы Оюутныг Дэмжих Байгууллага (JASSO)*3
Орон нутгийн захиргаа, хувийн хэвшлийн байгууллагуудын тэтгэлэг	17 байгууллага	60,000 йен-200,000 йен	526 US\$-1,754 US\$	Орон нутгийн захиргаа, хувийн хэвшлийн байгууллага*4
Сургуулиас оюутандаа олгодог тэтгэлэг, сургалтын төлбөрөөс чөлөөлөх буюу хөнгөлөх тогтолцоо	-	-	-	Суралцах гэж буй сургууль

(Нэг ам. долларыг 114 иенээр тооцов)

*1 Сурах, судалгаа хийх бүс нутгаасаа хамаараад тэтгэлгийн хэмжээ нэмэгдэх нь бий.

*2 Зарим нэг улс орны хувьд оршин сууж буй улсын засгийн газрын байгууллага хариуцаж ажиллах тохиолдол бий.

*3 https://www.jasso.go.jp/en/study_j/scholarships/shoueihi/yoyakuseido/

*4 Япон явахаас өмнө тэтгэлэг авах нь шийдэгдэх эсэх талаар дээрх байгууллагуудаас тодруулаарай. https://www.jasso.go.jp/en/study_j/scholarships/brochure.html


Япон явахаасаа өмнө бүртгүүлэх тэтгэлэг (Их дээд сургуулийн оюутан солилцооны тэтгэлэг)

Төрөл	Хэн хамрагдах, олгох байгууллагын тоо	Сарын тэтгэлэг	Ам. доллароор	Хаанаас лавлах
Гадаад суралцахыг дэмжих тогтолцоо (Гэрээний дагуу суралцуула)-ны тэтгэлэг	Суралцах хугацаа нь 8 хоногос нэг жил хүртэл, их дээд сургууль хоорондын оюутан солилцооны гэрээний дагуу суралцах гадаад оюутан	80,000йен	702US\$	Одоо сурч буй сургууль

Японд очсоныхоо дараа бүртгүүлэх тэтгэлэг


Төрөл	Хэн хамрагдах, олгох байгууллагын тоо	Сарын тэтгэлэг	Ам. доллароор	Хаанаас лавлах
Reservation Program for Monbukagakusho Honors Scholarship for Privately Financed International Students (Гадаад оюутан дэмжих хөтөлбөрийн тэтгэлэг захиалах тогтолцоо)	Аспирантур (магистр, докторын оюутан), судлаач оюутан (аспирантур), их дээд сургуулийн факультет, богино хугацааны дээд сургууль, техникийн коллеж (3-р курсээс), мэргэжлийн сургуулийн оюутан, гадаад оюутанд зориулсан тусгай сургалт, нарийн мэргэжлийн анги, бэлтгэл курсын оюутан	48,000 йен	421US\$	Японд сурч буй сургууль
	Япон хэлний боловсролын байгууллага	30,000 йен	263US\$	
Орон нутгийн захиргаа, хувийн хэвшлийн байгууллагуудын тэтгэлэг	132 байгууллага	20,000 йен-310,000йен	526US\$-1,754US\$	Японд сурч буй сургууль, эсхүл тэтгэлэг олгож буй байгууллага
Сургуулиас оюутандаа олгодог тэтгэлэг, сургалтын төлбөрөөс чөлөөлөх буюу хөнгөлөх тогтолцоо	-	-	-	Японд сурч буй сургууль

Тэтгэлэг, сургалтын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх тогтолцооны талаар судлаарай!

 “Японд суралцах тэтгэлгийн танилцуулга” (Япон, англи хэл дээр)
Бэлтгэсэн: Японы Оюутныг Дэмжих Байгууллага (JASSO)
https://www.jasso.go.jp/en/study_j/scholarships/brochure.html

Дараах вэб сайтуудаас мөн оюутны тэтгэлгийн талаарх мэдээлэл хайж болно.

 Их дээд сургуулийн тэтгэлэг, сургалтын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх тогтолцооны талаар хайх (JASSO)
https://www.jasso.go.jp/en/study_j/search/daigakukensaku.html

 Тэтгэлгийн талаар мэдээлэл хайх (JAPAN STUDY SUPPORT)
<https://www.jpss.jp/en/scholarship/>



Энд бичигдээгүй тэтгэлэг ч бий тул энэ талаар сургуулиасаа тодруулаарай.

ЦАГИЙН АЖИЛ

Хувийн зардлаар сурч буй гадаад оюутны **76 орчим хувь** нь цагийн ажил хийдэг бөгөөд сарын дундаж цалин **59,000 иен (518US\$)** орчим байдаг. Зөвхөн цагийн ажил хийгээд хичээлийн төлбөр болон амьжиргааны зардлаа төлж дийлэхгүй тул төсөв мөнгөө төлөвлөхдөө цагийн ажлаар хязгаарлахгүй байх хэрэгтэй.



Цагийн ажил хийхийн тулд дараах нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Үүнийг зөрчвөл шийтгэл хүлээлгэх буюу албадан гаргах арга хэмжээ авдаг.

1. Ойролцоох Гадаадын Иргэн, Харьяатын Газраас “Статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” авах. 3 сараас дээш хугацаагаар “Сурах” гэсэн оршин суух зөвшөөрөлтэй хүн Японы хилээр нэвтрэх үедээ “Статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” авахаар хүсэлт гаргаж болно.
2. Хичээл сурлагад саад болохооргүй байх
3. Сургалтын төлбөр болон шаардагдах бусад зардалд зарцуулах зорилгоор хийх. Мөнгө хураах, ар гэр лүүгээ мөнгө илгээх зорилгоор хийхгүй байх
4. Садар самууны төрлийн ажил хийж болохгүй. ※ Хуулиар хориглосон байдаг.
5. **Нэг долоо хоногт 28 цагаас (урт хугацааны амралтын үед өдөрт 8 цаг) хэтрэхгүй байх**
6. Боловсролын байгууллагад харьяалагдаж байх үедээ хийх

Ажил шийдэх үедээ анхаарах зүйлс!

Японд сурах зорилгоосоо хазайх, эрүүл мэндээрээ хохиртол хэт их ажилахгүй байх!

◎ Хичээл сурлагад саад болох эсэх

Шөнө орой болтол болон урт цагаар ажиллах нь дараагийн өдөрт нөлөөлөх эсэх

◎ Ажлын хөлс, төлбөрийн хэлбэр

Ажлын хөлсийг өдрөөр, 7 хоногоор, сараар төлдөг эсэх, төлбөрийг бэлнээр эсхүл шилжүүлгээр хийдэг эсэх

◎ Хийх ажил аюулгүй эсэх

Аюултай ажил эсэх, ажлын үеэр осол гарч мэдэх эсэх
Цагийн ажлыг харьяалагдаж буй сургууль дээр танилцуулдаг.



Зөвлөгөө

Цагийн ажлаас болоод хичээлийн ирц хүрэхгүй болох, хичээлээ орхигдуулснаас оршин суух хугацаагаа сунгуулж чадалгүй нутаг буцаж буй оюутнууд жил бүр гарч буй тул энэ тал дээр сайтар анхаараарай.

Гадаад оюутнуудын ихэвчлэн хийдэг цагийн ажлын төрөл

	Төрөл	Эзлэх хувь
1	Ресторан, зоогийн газар	41.9%
2	Худалдаа, борлуулалт	28.9%
3	Хичээл заах, судалгааны туслах	7.3%
4	Бичгийн болон аман орчуулга	6.7%
5	Хэлний багш	6.2%
6	Цэвэрлэгээний ажил	5.5%
7	Зочид буудлын хүлээн авах, зөөгч	5.3%
8	Гэрийн багш	4.7%

Эх сурвалж: Хувийн зардлаар сурах гадаад оюутны аж байдлын судалгаа, 2017 (JASSO)

Цагийн ажлын хөлс

Цагийн хөлс	Эзлэх хувь
800 иен хүртэл	5.4%
800-1,000 иен	42.4%
1,000-1,200 иен	39.4%
1,200-1,400 иен	6.9%
1,400 иенээс дээш	4.8%
Тодорхойгүй	1.0%



“Японд суралцангаа мөнгө хийж болно” гэж сурталчлах зуучлагч байгууллагаас болгоомжлох хэрэгтэй.

Сүүлийн жилүүдэд зарим зуучлагч байгууллага дараах байдлаар алдаатай мэдээлэл гаргаж буй тул анхаараарай.

“Нэг цагт 3,000 иен (26US\$)-ий цалин авах боломжтой”

→ **✗ Цагийн ажлын хөлс нэг цагт 900 иен (8US\$) орчим байдаг.**

“Суралцангаа цагийн ажил хийж олсон мөнгөөрөө сургалтын төлбөр, амьжиргааны зардлаа бүрэн төлж, нутаг руугаа мөнгө илгээх боломжтой”

→ **✗ Боломжгүй. (Дунджаар 59,000 иен (518US\$))**

АМЬДРАХ БАЙР СУУЦ

Орон нутгийн захиргаа болон сургуулийн мэдлийн оюутны байр байдаг боловч гадаад оюутны **75 орчим хувь** нь түрээсийн байранд амьдардаг. Сургуульд тэнцсэн мэдэгдэл аваад түрээсийн байрны мэдээлэл даруйхан цуглуулаарай. Мэдээллийг 1) Сургуулийнхаа гадаад оюутны алба, 2) Интернет, мэдээллийн сэтгүүл, 3) Өөрийн амьдрахыг хүсч буй орон нутгийн үл хөдлөх хөрөнгийн зуучийн газраас авч болно.

Оюутны байр

Давуу тал

- Зардал бага (Баталгаа мөнгө, талархлын төлбөр, гэрээ сунгасны төлбөр гарахгүй.)
- Тавилга, гэр ахуйн цахилгаан бараа зэргийг анхнаасаа суурилуулсан байх нь бий.

Сул тал

- Өрөөний тоо хязгаартай тул хүссэн хүн бүхэн орох боломжгүй.
- Орой харих болон өглөө босох цаг заасан байдаг.
- Гал тогоо, ариун цэврийн өрөө, шүршүүр нь дундын хэрэглээнийх байдаг.

Зөвлөгөө

Байрны зардал (Сард)

Оюутны байр: Төлбөр 28,000 йен

(JASSO, Токиогийн Япон хэлний Сургалтын Төвийн хувьд)

Түрээсийн байр: Эрэлт ихтэй галт тэрэгний буудалтай эсэх, буудлаас хэр хол болох, баригдсан жил зэргээс шалтгаалан ихээхэн ялгаатай байдаг. Орон нутагт 30,000-40,000 йен орчим, Токиод бол 60,000 йенд хайж болно.

Хог хаях

Японд хог хаях хатуу журамтай. Үүнийг баримтлаагүйгээс ойр орчмын оршин суугчидтай зөрчилдөх тохиолдол гарна. Хогоо ангилан, заасан газар болон цагт нь гарган хаяж байгаарай.



Түрээсийн байр

Давуу тал

- Өөрийн хэмнэлээр амьдрах боломжтой.
- Мөнгөө зөв тооцож хэрэглэж сурна.

Сул тал

- Ихэнх тохиолдолд толгой мөнгө (Хэдэн сарын байрны хөлс нийлүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байдаг ба баталгаа мөнгө гэж хэлэх газрууд ч бий.), талархлын мөнгө, зуучлалын хөлс зэргийг урьдчилан төлөх хэрэгтэй болно.
- Түрээсийн гэрээ байгуулах нь ажиллагаа ихтэй.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл болон тавилгаа бүгдийг нь өөрөө бэлдэх хэрэгтэй болно.

Батлан даагч

Японд байр түрээслэхэд “Батлан даагч” шаардлагатай болдог. Хэрвээ та байрныхаа хөлсийг хугацаанд нь төлөөгүй, байрны эд хогшил эвдэлсэн хэрнээ засварын хөлс төлөөгүй бол байрны эзэн нь батлан даагчаар төлүүлэхээр нэхэмжилдэг. Таньдаг япон хүн цөөтэй гадаад оюутнуудад сургуулийн холбогдох хүмүүс (сургуулийн багш, ажилтан) батлан даагч болж өгдөг тогтолцоо ч байдаг. Мөн “Батлан даалтын төлбөр” төлбөр төлөх гэрээ байгуулснаар “Батлан даагч” хэрэггүй болох тохиолдол ч бий.

※ Гадаад оюутанд зориулсан орон байрны нэгдсэн даатгал

Олон нийтийн ашгийн сан болох Японы Олон Улсын Боловсролыг Дэмжих Холбоо (JEES) энэхүү ажлыг эрхэлдэг бөгөөд гал түймэр гэх мэт гамшгийн хохирлыг барагдуулах болон байранд ороход батлан даагч болсон хүнд ямар нэгэн төвөг чирэгдэл учруулахгүйн тулд бий болгосон тогтолцоо юм. Энэ даатгалд хамрагдаж болох эсэхээ одоо сурч буй сургуулиасаа болон сурахаар төлөвлөж буй сургуулиасаа лавлаарай.

Байр хайхад бодолцох зүйлс

1. Түрээсийн төлбөр болон анх шаардагдах зардал хэд болох
2. Сургууль хүртэлх зай, явах хугацаа
3. Өрөөний багтаамж, тохижилт
4. Эргэн тойрны орчны тав тухтай байдал
Галт тэрэгний буудал ойрхон, шоппинг хийхэд амар эсэх гэх мэт

ЭРҮҮЛ МЭНД, ХОХИРЛЫН БОЛОН ОЮУТНЫ ДААТГАЛ

Эрүүл мэндийн даатгал (ҮЭМД)

Японд эмчилгээний зардлын дарамтыг багасгах зорилготой даатгалын тогтолцоо байдаг. Японд 3 сараас дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэн “Эрүүл мэндийн даатгал”-д хамрагдах ёстой.

※ 3 сараас доош хугацаагаар суралцах оюутан сурч буй сургуулиасаа тодруулаарай.

■ Хамрагдахын тулд

Өөрийн оршин суугаа газрын захиргаанд очиж оршин суугчаар бүртгүүлсэний дараа зохих бүрдүүлэлтийг хийнэ.

■ Даатгалын хураамж

Ерөнхийдөө жилийн хураамж нь 20,000 орчим йен байдаг. Гэхдээ тухайн хот, дүүрэг, орон нутгаас болон даатгуулагчийн орлогоос хамаарч даатгалын хураамж нь ялгаатай байдаг.

Оюутны эрүүл мэндийн даатгалыг хөнгөлдөг, нөхөн олгодог тогтолцоотой хот, дүүрэг, тосгон байдаг тул лавлаж тодруулаарай.

■ Даатгалын агуулга

Гэмтэл болон өвчний улмаас эмчилгээ хийлгэх тохиолдолд даатгалын үнэмлэхээ үзүүлэхэд эмчилгээний нийт зардлын 70%-ийг улсын даатгалаас төлдөг. Хувь хүний төлөх эмчилгээний зардал 30% болдог. Даатгуулагч эмчилгээний зардлын 30%-ийг төлнө гэсэн үг. Гэхдээ даатгал хамаарахгүй эмчилгээ хийлгэх бол эмчлүүлэгч өөрөө бүх зардлыг гаргах ёстой.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бол 1 сарын эмчилгээний зардал өндөр гарсан тохиолдолд өөрийн төлөх хэсгээс илүү гарсан хэсэг нь өндөр төлбөртэй эмчилгээний зардал гэж дараа нь эргэн төлөгддөг. Мөн эмнэлэгт хэвтэх үедээ босго дүнг төлөх бичиг урьдчилан авснаар эмнэлгийн хүлээн авах дээр зөвхөн өөрийн төлөх хэсгийг төлж болно.

Хохирлын даатгал, оюутны даатгал

Эрүүл мэндийн даатгалд хамаарахгүй осол гэмтлийг нөхөн төлөх даатгал байдаг. Энэ нь “Гэнэтийн ослын даатгал” болон “Хувь хүний нөхөн төлбөрийн хариуцлагын даатгал” юм. Оюутнууд ч даатгуулж болдог.

Жишээлбэл, дараах тохиолдолд эдгээр даатгалаар хохирлыг барагдуулж болно.

- Шарсан хоолны тосноос гал авалцаж, гал тогоо харлаж, ханын хулдаасыг солих шаардлагатай болох
- Унадаг дугуйгаар явж байгаад явган хүнийг мөргөж бэртээсэн тул тухайн хүний эмчилгээний зардлыг төлөхөөс өөр аргагүй болох
- Эзгүй хойгуур гэрт байсан компьютер, зургийн аппарат, видео камераа хулгайд алдах

Сургуулиас тань даатгалын талаар танилцуулдаг тул судалж үзээрэй.



“Оюутны гэнэтийн ослын даатгал”-ын тогтолцоо

Энэхүү даатгалын системд Японы их дээд сургуулиудын 96% нь хамрагдсан байдаг бөгөөд Японы Олон Улсын Боловсролыг Дэмжих Нийгэмлэгийн даатгалын тогтолцоо юм. Мөн даатгалын нөхөн төлбөр хангалттай олгодог “Оюутны гэнэтийн ослын даатгал хавсарсан өргөн сонголт бүхий оюутны амьдралын даатгал” гэж бас байдаг.

※ Сургуулиасаа хамаараад хамрагдах боломжгүй тохиолдол бий тул сургуулиасаа энэ талаар тодруулаарай.

<http://www.jees.or.jp/gakkensai/>



Оюутны даатгал

Их дээд сургуульд суралцаж буй үедээ хамрагдаж болох даатгал

<https://kyosai.univcoop.or.jp/english/index.html>



ДАДЛАГА ХИЙХ

Оюутнууд сургуульд сурч байхдаа байгууллагууд дээр очиж өөрийн сонгосон мэргэжил, ирээдүйн карьертайгаа холбоотой ажил хийж үзэх тогтолцоог “Дадлага” гэдэг. Сургалтынхаа нэг хэсэг хэмээн үзэж кредит олгодог сургууль ч байдаг. Дадлага хийлгэдэг эсэх, дадлагын кредит олгодог эсэх талаар сургуулиасаа шууд асууж тодруулаарай.

Хэрэв цалинтай дадлага хийх бол “Статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” авах шаардлагатай. 7 хоногт 28 цагаас илүүтэй дадлага хийхийг хүсэж буй бол дадлагын агуулгыг тодорхой гаргасан материалын хамт тухайн орон нутгийн Гадаадын Иргэн, Харьяатын Газарт “Статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” авахаар хандаарай.

■ Цагийн ажил, дадлагын ялгаа

Цагийн ажил: Хөдөлмөрлөж мөнгө олох хөдөлмөрийн хэлбэр

Дадлага: Ажиллах боломжоор хангаж, ирээдүйн карьер төлөвлөлтөд тус нэмэр болох үүднээс хийлгэх ажлын хэлбэр. Цалин хөлсгүй байх нь олонтаа.

■ Дадлага хийх газраа хэрхэн хайх

- 1. Ажил хайлтын төрөлжсөн сайтууд**
Мэргэжлийн чиглэл болон ажлын төрөл хамаарахгүйгээр олон дадлагажигчийг шалгаруулж авдаг.
- 2. Их дээд сургуулийн ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх алба**
Зарын самбар зэргийг байнга шалгаж байгаарай.
- 3. Мэргэжлийн зуучлагч байгууллага**
Дадлага хийх газрын талаар сайтар мэдэх тул оюутан болон байгууллагыг сайн холбож өгдөг.

■ Өөр орны их сургуулийн оюутан Япон улсад дадлага хийхэд олгох оршин суух статус

Япон улсаас өөр орны их дээд сургуулийн оюутан тухайн их дээд сургуулийнхаа кредит бүрдүүлэх сургалтын системийн хүрээнд Японы байгууллагатай байгуулсан гэрээний дагуу ажлын дадлага хийхээр Японд ирсэн тохиолдолд дадлага цалинтай эсэх болон оршин суух хугацаанаас хамаарч оршин суух статус нь “Тусгай үйл ажиллагаа (Designated Activities)”, “Соёлын үйл ажиллагаа (Cultural Activities), “Түр хугацаагаар оршин суух (Temporary visitor)”-ын аль нэгээр гардаг.

Эдийн Засаг, Аж Үйлдвэрийн Яамнаас хэрэгжүүлэх глобалчлалыг гүнзгийрүүлэх дадлага (Гадаад улс орны их сургуулийн оюутан болон төгсөгчид хамрагдана)

Эдийн Засаг, Аж Үйлдвэрийн Яам нь гадаадын боловсон хүчинг Японы ААН-үүдэд дадлага хийлгэх ажлыг хариуцан ажилладаг.

Лавлах: Эдийн Засаг, Аж Үйлдвэрийн Яамны Гадаад Худалдаа, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хэлтэс, Техникийн Хамтын Ажиллагааны Тасаг
Утас: (+81) 3-3501-1937

Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Гадаад Иргэдийн Ажил Эрхлэлтийг Дэмжих Төв (Токио, Нагоя, Осака)

Ажлын зарын мэдээлэл өгөх, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх болон ажил танилцуулах, дадлага хийх бүртгэл хийдэг.

Лавлах: Токио <https://jsite.mhlw.go.jp/tokyo-foreigner/>
Нагоя <https://jsite.mhlw.go.jp/aichi-foreigner/>
Осака <https://jsite.mhlw.go.jp/osaka-foreigner/>



ЯПОНД АЖИЛД ОРОХ

Японд “Иргэний харьяалал үл харгалзан шилдэг хүний нөөцтэй болох”, “Гадаад хэл болон гадаад улсуудын байдлыг мэддэг ажилтан хэрэгтэй”, “Янз бүрийн туршлагатай хүмүүсийг ажилд идэвхийлэн авах хэрэгтэй” гэсэн бодолтой компани, байгууллагууд олширч, гадаад оюутныг ажилд авах нь ихэсч байгаа билээ. Гэхдээ гадаад оюутан Японд ажилд орох нь тийм ч амар бус. Доорх вэбсайтад ажил хайж байсан туршлага болон ажилд орохтой холбоотой төрөл бүрийн ивэнтийн мэдээлэл байгаа тул эдгээрийг ашиглан ажлаа эртхэн хайж эхлээрэй.

Японы Засгийн Газар гадаад оюутныг Японы компани, ААН-үүдэд ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх үүднээс Японы Гадаад Худалдааг Дэмжих Байгууллага (JETRO) дээр **"Өндөр чадвартай гадаад боловсон хүчний ажил эрхлэлтийг дэмжих портал сайт Open for Professionals"**-ыг нээн ажиллуулж байна. Тус вэбсайтад дараах мэдээлэл тавигдсан байгаа.

- Улсын байгууллагуудаас зохион байгуулдаг хөдөлмөрийн яармаг, дадлага (Оролцохоор бүртгүүлэх боломжтой)
- Өмнө нь Японд сурч байсан гадаад хүмүүсийн ажиллаж буй компани
- Японд оршин суух статус болон улсын даатгалын тогтолцоо
- Хөдөлмөрийн талаар зөвлөгөө өгөх цонх

2019 оны 4 сараас англи хэл дээр мэдээлэл тавьж эхэлнэ. Мөн ажил хайхад тань нэмэр болно гэсэн үүднээс гадаад хүн авах сонирхолтой Япон компаниудын мэдээлэл болон холбоо барих хаягийг мөн тавьсан байгаа. Японд ажилд орох сонирхолтой хүмүүс энэхүү вэбсайтаар заавал зочлоорой!



Гадаад оюутны ажил хайх гарын авлага (JASSO)

https://www.jasso.go.jp/en/study_j/job/


Japan Alumni eNews (JASSO)

https://www.jasso.go.jp/en/study_j/enews/

Өндөр чадвартай гадаад боловсон хүчний ажил эрхлэлтийг дэмжих портал сайт "Open for Professionals"
<https://www.jetro.go.jp/hrportal>

Японд гадаадын оюутнуудын ажилд орж буй байдал

■ “Сурах” статусаас ажиллах статус руу өөрчлөлт хийлгэх хүсэлтэд зөвшөөрөл олгосон тоо




Эх сурвалж: “Гадаад оюутнуудын Японы байгууллагад ажилд орсон байдал”, 2017 он (Гадаадын Иргэн, Харьяатын Газар)

■ Эзлэх хувь, ажлын төрлөөр (Эхний 10 байр)

1-р байр	Худалдаа, гадаад худалдаа	9.5%
2-р байр	Компьютер, IT	7.7%
3-р байр	Ресторан, зоогийн газар	5.2%
4-р байр	Боловсрол	5.0%
5-р байр	Зочид буудал	3.8%
6-р байр	Ердийн техник	3.1%
7-р байр	Цахилгаан бараа	3.1%
8-р байр	Хүнс	2.7%
9-р байр	Барилга	2.7%
10-р байр	Тээвэр	2.2%

■ Анхны цалин (Сарын)



■ Оршин суух статусаа өөрчлөх

Гадаад оюутан Японд ажилд орсон бол оршин суух статусаа “Сурах” гэсэн статусаас “Engineer, Specialist in Humanities, International Services” гэх зэрэг ажиллах боломжтой статус болгон өөрчлөх шаардлагатай. Оршин суух статусыг өөрчлөхөд баруун талд заасан зүйлийг харгалзан үздэг.

■ Ажилд орж чадаагүй тохиолдолд

Японы их дээд сургууль^{*1}, эсхүл мэргэжлийн сургууль^{*2} төгсөх хүртлээ ажилд орж чадаагүй тохиолдолд ч “Сурах” статусаа “Тусгай үйл ажиллагаа” гэсэн статусаар сольж болно. Ингэснээр төгссөнийхөө дараа 1 жилийн хугацаанд үргэлжлүүлэн ажил хайх боломжтой болно. Энэ тохиолдолд оршин суух хугацаа 6 сар байх бөгөөд ерөнхийдөө нэг удаа сунгуулж болно.^{*3,4}

1. Боловсрол	Японы болон гадаадын их дээд сургууль, богино хугацааны дээд сургууль, техникийн коллеж төгсөгч Японы мэргэжлийн сургууль төгсөж, “Мэргэжилтэн” цол авсан хүн
2. Хийх гэж буй ажлын агуулга	Ажиллах гэж буй байгууллагад хийх ажлын агуулга эзэмсэн мэргэжилтэй чинь холбоотой байна уу гэдгийг чухалчилж үздэг. Жишээ нь, хувцас загвараар суралцсан хүн компьютерийн программистаар ажиллахаар болсон бол оршин суух статусын өөрчлөлт хийлгэхэд хэцүү.
3. Цалин	Япон хүнтэй ижил түвшний буюу түүнээс дээш цалинтай байх
4. Байгууллагын бодит байдал	Ажилд орох гэж буй компанийн санхүүгийн байдал болон үйл ажиллагаа тогтвортой байх

*1 Богино хугацааны дээд сургууль болон аспирантур багтана. Гэхдээ тусгай курсад сурах гадаад оюутан, сонсогч оюутан, судлагч оюутан, судлаач оюутан хамаарахгүй.

*2 Техникийн мэргэжилтэн цол авсан хүн л хамаарна.


*3 Сургуулийн тодорхойлолт хэрэгтэй.

*4 Тодорхой шаардлага хангасан тохиолдолд төгсөөд 2 дахь жилдээ ч үргэлжлүүлэн ажил хайж болдог. Тодорхой мэдээллийг орон нутгийн Гадаадын Иргэн, Харьяатын Газраас лавлаарай.


СТАТИСТИК

Япон дахь гадаад оюутны тоо


2018 оны 5 сарын 1-ний байдлаар



Гадаад оюутны тооны өөрчлөлт



Гадаад оюутны эзлэх хувь, сурч буй салбараар (Дээд боловсролын байгууллага)



Гадаад оюутны тоо, боловсролын түвшингээр (Хүн)

	Улсын	Муж, хотын	Хувийн	Нийт
Аспирантур	31,175	2,043	16,426	50,184
Их дээд сургууль (факультет)	12,554	1,855	70,448	84,857
Богино хугацааны дээд сургууль	0	19	2,420	2,439
Техникийн коллеж	467	0	43	510
Мэргэжлийн сургууль	0	19	67,456	67,475
Бэлтгэл сургалтын анги			3,436	3,436
Япон хэлний сургалтын байгууллага		58	90,021	90,079
Нийт	44,736	3,994	250,250	298,980

Гадаад оюутны тоо (улс, бүс нутгаар) (Хүн)

Эхний байр	Улс, бүс нутаг	Гадаад оюутны тоо
1-р байр	Хятад	114,950
2-р байр	Вьетнам	72,354
3-р байр	Непал	24,331
4-р байр	Солонгос	17,012
5-р байр	Тайвань	9,524
6-р байр	Шриланка	8,329
7-р байр	Индонез	6,277
8-р байр	Мьянмар	5,928
9-р байр	Тайланд	3,962
10-р байр	Бангладеш	3,640

Эх сурвалж: Гадаад оюутны суралцах байдлын судалгаа, 2018 он
https://www.jasso.go.jp/about/statistics/intl_student_e/index.html

Дээд боловсролын байгууллагын тоо (Сургууль)

	Улсын	Муж, хотын	Хувийн	Нийт
Аспирантур	86	83	467	636
Их дээд сургууль (факультет)	82	91	583	756
Богино хугацааны дээд сургууль	0	17	314	331
Техникийн коллеж	51	3	3	57
Мэргэжлийн сургууль	9	186	2,611	2,806

※ Хувийн сургуульд Нээлттэй их сургууль (the Open University of Japan)-ийг оруулан тооцов. Эх сурвалж: Сургуулийн үндсэн судалгаа, 2018 он (Боловсрол, Шинжлэх Ухааны Яам) 2018 оны 5 сарын 1-ний байдлаар

ЯПОНД СУРАЛЦАХ ТАЛААРХ АСУУЛТ ХАРИУЛТ

Q 1. Бага, дунд болон ахлах сургуульд сурч байхдаа хэдэн жилийг нь Японы сургуульд суралцаж өнгөрөөсөн.

2. Японд ахлах сургууль төгссөн.

3. Японы болон өөр улсын хоёр иргэншилтэй. Энэ тохиолдолд гадаад оюутны элсэлтийн шалгалт өгөхөөр хүсэлт гаргаж болох уу?

A Өргөдөл өгөх эрхтэй эсэхийг сургууль хянан үзэж шийдвэр гаргана. Өргөдөл гаргахаасаа өмнө тухайн сургуультайгаа урьдчилан холбоо барьж, өргөдөл гаргах эрхтэй эсэхээ тодруулаарай. Сургуулиасаа хамаараад япон оюутнуудын өгдөг элсэлтийн шалгалтыг өгөх шаардлагатай байх тохиолдол ч бий

Q Хөгжлийн бэрхшээлтэй хүн элсэлтийн шалгалт өгөх үедээ болон элсэн орсны дараа ямар нэгэн хөнгөлөлт эдлэх үү?

A Хөгжлийн бэрхшээлтэй гадаад оюутнууд ч сургуулиасаа дэмжлэг аван Японд суралцаж байна. Өвчтэй болон хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар элсэлтийн шалгалт өгөх үед болон сургуульд элсэн орсны дараа ямар нэгэн дэмжлэг авахыг хүсч буй бол сургуульд элсэх өргөдөл гаргахаасаа өмнө энэ талаар тухайн сургуультайгаа зөвлөлдөх хэрэгтэй.

Q Элсэлтийн шалгалтыг заавал Японд очиж өгөх шаардлагатай юу?

A Японд элсэлтийн шалгалтаа авдаг сургууль олон. Гэхдээ зөвхөн бүрдүүлж өгсөн элсэлтийн материалыг үндэслэн сонгон шалгаруулалт хийдэг, интернетээр ярилцлагын шалгалт авдаг, элсэгчийн байгаа улсад элсэлтийн шалгалт авдаг сургууль ч байдаг (Хуудас 30-ийн 7. Шалгалт өгөхөөр Япон явах үеийн бүрдүүлэлтийг харах).

Q Их дээд сургуульд зэрэглэл байдаг уу?

A Байгууллагуудын тус тусын өнцөг, шалгуураар гаргасан зэрэглэл байдаг хэдий ч Японы Засгийн Газраас албан ёсоор гаргасан зэрэглэл бол байхгүй. Тэдгээр зэрэглэлээр дээгүүр үзүүлэлттэй гээд заавал танд таарах сургууль байх албагүй тул багш нараасаа болон Японд сурч байсан хүмүүсээс асууж, ЯОДБ болон их дээд сургуулиудын вэбсайтаас мэдээлэл цуглуулж, өөрийн хүсэл сонирхолд нийцсэн сургуулиа хайж олоорой.

ЯПОНД СУРАХЫГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН ГАДААД САЛБАРУУД

Боловерол, Шинжлэх Ухааны Яаманд Японд суралцах талаар мэдээлэл өгөх, шилдэг гадаад оюутан шалгаруулах үйл ажиллагааг дэмжих үүднээс зохицуулагч ажиллуулдаг. Мэдээлэл цуглуулах болон Японд суралцахаар төлөвлөх үедээ зөвлөгөө аварай.

Мьянмар, Янгон
Окаяма их сургууль
<http://www.okayama-u.ac.jp/user/myanmar/index.html>



Замби / Русака
Хоккайдо их сургууль
<https://www.hokkaido-university-lusakaoffice-zm.com/>



Энэтхэг / Нью Дэли
Токио их сургууль
<https://www.u-tokyo.ac.jp/adm/utindia/en/index.html>



Бразил / Сан Пауло
Цүкүба их сургууль
<http://www.global.tsukuba.ac.jp/overseas/s%C3%A3o-paulo?language=en>



Орос / Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн орнууд
Хоккайдо, Цүкүба, Нийгата их сургууль
Бэлтгэж байгаа



Ойрх Дорнод, Хойд Африк
Кюшю их сургууль
<https://jmena.jp/en>



МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

Японд суралцах талаархи үндсэн мэдээлэл



Японы Оюутныг Дэмжих Байгууллага (JASSO)-ын вэб сайт

https://www.jasso.go.jp/en/study_j/index.html

- Сургууль хайх
- Тэтгэлгийн мэдээлэл
- Японд суралцах шалгалт (EJU)
- Японы Оюутныг Дэмжих Байгууллагын зохион байгуулдаг Японд суралцах үзэсгэлэн яармаг гэх мэт https://www.jasso.go.jp/en/study_j/event/index.html



- Японд суралцахтай холбоотой материал, гарын авлагатай танилцах хэсэг

Японы боловсролын байгууллагуудын товхимол болон Японд суралцахтай холбоотой ном хэвлэл үзэх боломжтой. https://www.jasso.go.jp/en/study_j/openbase/index.html



Япон хэл



Англи хэл



Япон Улсын ЭСЯ, Консулын Газар Гадаад улс дахь Япон улсын Дипломат Төлөөлөгчийн Газрын жагсаалт (Гадаад Харилцааны Яам)

https://www.mofa.go.jp/about/emb_cons/over/index.html

- Японд суралцах талаархи мэдээлэл
- Япон улсын Засгийн Газрын тэтгэлгийн талаарх мэдээлэл
- ※ Японд суралцах талаар зөвлөгөө өгдөг ЭСЯ, консулын газар ч бий.



“STUDY IN JAPAN” ВЭБСАЙТ

<https://www.studyinJapan.go.jp/en/>

- Японд сурахар төлөвлөх
- Японд амьдрах
- Япон дахь ажил, карьер

Японы Оюутныг Дэмжих Байгууллагын зүгээс та бүгдийн Японд суралцах ажил үйл үр өгөөжтэй байгаасай гэж хүсэж байна

Бие Даасан Захиргааны Байгууллага болох Японы Оюутныг Дэмжих Байгууллага (JASSO) нь Японы Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь оюутныг дэмжих ажлыг удирдан явуулдаг гол байгууллагынхаа хувьд тэтгэлэг, гадаад оюутныг дэмжих болон оюутны ахуй амьдралыг дэмжих ажлыг цогцоор нь хэрэгжүүлж, дараагийн үеийн нийгмийг авч явах хүн чанартай, бүтээлч боловсон хүчинг хөгжүүлэхийн зэрэгцээ олон улсын ойлголцол, харилцаа солилцоог хөгжүүлэхийг зорин ажилладаг.

1 Оюутанд тэтгэлгийн зээл олгох

Эдийн засгийн асуудлаас болоод суралцахад нь хүндрэл учирч буй япон оюутнуудад тэтгэлгийн зээл олгох ажлыг зохион байгуулдаг. Мөн оюутны олон талт эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тэтгэлгийн тогтолцоог сайжруулах, хүсэлт гаргах процедурын ажлыг хөнгөвчлөх, оюутны тэтгэлгийн талаарх мэдээллийг хүртээмжтэй болгох, зээлийн буцаан төлөлтийг зүй зохистойгоор хангах ажлыг хариуцан ажилладаг.

2 Гадаад оюутныг дэмжих

Гадаад оюутанд тэтгэлэг олгох, төрөл бүрийн оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, Японд суралцах шалгалт зэргийг зохион байгуулах замаар сургуульд элсэх процедурыг сайжруулах, Японд сурахтай холбоотой мэдээлэл цуглуулах, түгээх зэрэг ажлыг эрхлэн явуулдаг.

3 Оюутны ахуй амьдралыг дэмжих

Их дээд сургуулиудын хэрэгжүүлдэг оюутны ахуй амьдралыг дэмжих ажилд хувь нэмэр оруулах үүднээс оюутны ахуй амьдралыг дэмжихтэй холбоотой үр өгөөжтэй бодит ажлын талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ түүнийг түгээх ажлыг явуулдаг. Мөн төрөл бүрийн үйлдвэрлэлийн дадлага сургалтын ажлаар дамжуулан их дээд сургуулийн оюутнуудад үзүүлэх үйлчилгээний ажлыг сайжруулах тал дээр дэмжлэг үзүүлэн ажилладаг.




Бие Даасан Захиргааны Байгууллага
Японы Оюутныг Дэмжих Байгууллага
JASSO Japan Student Services Organization

TEL: +81-3-5520-611 FAX: +81-3-5520-6121
2-2-1 Aomi, Koto-ku, Tokyo, 135-8630, Japan

infoja@jasso.go.jp


Гадаад салбар (JASSO, Японы Олон Улсын Боловсрол Солилцоо Мэдээллийн Төв)

 **Индонез** TEL (+62) 21-252-1912


JASSO Japan Educational Information Center, Jakarta
Summitas Tower I, 2nd Floor, Jalan Jenderal
Sudirman KAV 61-62 Jakarta 12190 INDONESIA
info@jasso.or.id
<http://www.jasso.or.id/>
<https://www.facebook.com/jasso.indonesia>

 **Солонгос** TEL (+82) 2-765-0141


JASSO Japan Educational Information Center, Seoul
#702 Garden Tower, 84 Yulgok-ro, Jongno-gu,
Seoul 03131 REPUBLIC OF KOREA
jasso@jasso.or.kr
<http://www.jasso.or.kr/>
<https://www.facebook.com/JASSO.Korea>

 **Тайланд** TEL (+66) 2-661-7057

JASSO Japan Educational Information Center, Bangkok
10F Serm-mit Tower, 159 Asok-Montri Rd.,
Bangkok 10110 THAILAND
info@jeic-bangkok.org
<https://www.jeic-bangkok.org/>
<https://www.facebook.com/JASSO.Thailand>

 **Малайз** TEL (+60) 3-2287-0812

JASSO Japan Educational Information Center, Kuala Lumpur
A-7-5, Northpoint Offices, Mid Valley City,
No.1, Medan Syed Putra Utara, 59200 Kuala Lumpur, MALAYSIA
enquiry@studyinJapan.org.my
<http://www.studyinJapan.org.my/>
<https://www.facebook.com/JASSO.Malaysia>

 **Вьетнам** TEL (+84) 24-3710-0226

JASSO Vietnam Office
4th Floor, CornerStone Building, 16 Phan Chu Trinh,
Hoan Kiem, Hanoi, VIETNAM
info@jasso.org.vn
<https://www.jasso.org.vn/>
<https://www.facebook.com/JASSO.Vietnam>

Хилийн чанад дахь салбар нэгжүүд дараах үйл ажиллагаа явуулдаг

- E-mail, уулзалт, утас, захиагаар зөвлөгөө өгөх
- Сургуулийн танилцуулга удирдамж, Япон суралцахад хэрэг болох ном товхимолтой танилцуулах
- Тухайн улсад зохион байгуулагдах танилцуулга семинар дээр мэдээлэл өгөх

<https://www.jasso.go.jp/ryugaku/about/jeic/index.html>